



ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ РҮҮ ХАМТДАА

Юнител группийн ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН 2023





ГАРЧИГ

БОНЗ-ЫН ХАНДЛАГА

Гүйцэтгэх захирлын зурвас	3
БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ	4
Оролцогч талууд	5

БАЙГАЛЬ ОРЧИН

Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал	7
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент	9
Хог хаягдлын менежмент	13
Байгаль хамгаалал (Ногоон байгаасай)	17

НИЙГЭМ

Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал	20
Ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллах нөхцөл, сайн сайхан байдал	23
Ажилтнуудын тогтвор суурьшил, идэвх оролцоо	26
Нийгэмд тустай ажлууд	29
Цахим хуваагдлыг бууруулах ажлууд	31
Нийлүүлэлтийн хэлхээний менежмент	34

ЗАСАГЛАЛ

Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал	36
Бизнесийн ёс зүй	38
Бизнес процессын менежмент	40
Компанийн засаглал	41

ХАВСРАЛТ

Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд ба тэдгээрийн тайлбар	44
Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс	45
Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс	48
Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын индекс	51

Энэхүү тайланд Юнител болон Юнивишн компанийн 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг тусгасан бөгөөд тайлангийн бичвэрийг Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын дагуу боловсруулж, салбарын Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн тайлагналын стандартад уялдуулсан болно.

Гүйцэтгэх захирлын зурвас

Юнител групп 2023 онд тогтвортой байдлын хүрээнд хийсэн ажлаа олон нийтэд танилцуулж байгаадаа баяртай байна.

Дэлхий ертөнц асар хурдацтай өөрчлөгдөж, бид макро эдийн засгийн хүндрэл, амьжиргааны өртөг, амьдралын чанарын асуудлууд, геополитик болон геоэдийн засгийн тодорхойгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээ тасалдал, технологийн хурдацтай өөрчлөлт, зохицуулалтын орчны тодорхойгүй байдал зэрэг олон сорилттой нүүр тулсаар байна. COVID-оос үүдэн дижитал шилжилт хурдассан нь технологийн дэвшлийн суурь болсон дэд бүтцийн эрэлтийг улам нэмэгдүүлж, технологийн үсрэнгүй өөрчлөлтөд биднийг хөтөллөө.

Бид харилцаа холбооны Юнител, Юнивишнийн үйлчилгээгээрээ дамжуулан хүмүүсийн амьдрах, ажиллах, сурч боловсрох, бусадтай харилцах гүүр болдог гэдэгт итгэдэг. Иймээс бид тогтвортой, хүртээмжтэй байдлыг цогцлоохоор нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын асуудлуудыг дараах байдлаар үйл ажиллагаандаа түсгэн, нөөц боломжоо дайчлан ажиллаж байна.

- Байгаль орчинд үзүүлэх нөлөөгөө багасгах
- Хязгаарлагдмал нөөцөөр өргөн хүртээмжтэй санаачилгуудыг хэрэгжүүлэх
- Нийгмийн цахим хуваагдлыг бууруулах
- Хүн төвтэй ажлын орчин бүрдүүлэх
- Бизнесийн үйл ажиллагаагаа ёс зүйтэй, тогтвортой явуулах
- Байгальд ээлтэй дадал, сэтгэлгээг олон нийтэд түгээх

Энэхүү тайлангаараа бид байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр хэрэгжүүлсэн ач холбогдол, нөлөө бүхий ажлуудаа хэрхэн хэрэгжүүлж буйгаа дэлгэрэнгүй өгүүллээ. Тухайлбал:

- Бид Монголдоо анхлан өөрийн үйл ажиллагаанаас үүсэж буй цахим хог хаягдлыг хариуцлагатайгаар удирдах санаачилгыг дэвшүүлж, олон талын хамтын ажиллагааны үрдүнд Юнивишн үйлчилгээнийхээ дагалдах төхөөрөмжүүдийн амьдралын мөчлөгийг оновчтой удирдаж эхэллээ. Түншүүд, хамтрагчид, бусад оролцогч талууд ч цахим хог хаягдлын хариуцлагатай менежментийн энэхүү уриалгад нэгдсээр байна.

- 2022 онд хот, хөдөөгийн цахим хуваагдлыг бууруулах зорилготойгоор туршилтын журмаар Дархан-Уул аймагт эхлүүлсэн Unitel HUB хөтөлбөр 2023 онд 12 аймагт тэлж өргөжлөө. Энэхүү санаачилга нь төр, хувийн хэвшлийн түншлэл (P2P partnership)-ийн амжилттай жишээ бөгөөд мянга мянган хүүхдийн шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи (ШИМТ)-ийн сонирхлыг дэмжихэд нөлөөлж буй. Бид энэхүү хөтөлбөрөө 21 аймагт нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

- Түүнчлэн бид бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйн дээд хэм хэмжээг баримталж, хэрэглэгч, түнш, ажилтнуудынхаа экспериенсийг сайжруулахын төлөө ажиллалаа.

Бидний энэхүү ажлууд бүхий л оролцогч талуудад тогтвортой, эерэг өөрчлөлтийг авчрахад хувь нэмрээ оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Цаашдаа ч бид бизнесийн үйл ажиллагаандаа дэлхийн стандартыг мөрдсөөр байх болно.

Илүү тогтвортой, хариуцлагатай бизнесийг бий болгоход чиглэсэн бидний ажилтай танилцаж, санал сэтгэгдлээ харамгүй хуваалцана гэдэгт итгэж байна.

ДОРЖДАГВЫН ЖАМЬЯНШАРАВ
ЮНИТЕЛ ГРУППИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ





БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ

Юнител групп 2023 онд байгаль орчин, нийгэм, засаглалын материаллаг байдлын үнэлгээг анх удаа хийж, компанийнхаа БОНЗ-ын асуудлуудыг нарийн тодорхойлон, үнэлсэн билээ. Ингэснээр байгууллагын тогтвортой байдлын хамрах хүрээ, үнэт зүйлс илүү тодорхой болж, тэдгээрийг сайжруулах, олон нийтэд таниулахад ихээхэн ач холбогдолтой.

Материаллаг асуудал гэдэг нь компанийн үнэ цэнд нөлөөлөх бүхий л асуудлыг хамруулдаг ойлголт юм. Уг ойлголтыг үнэлж эрэмбэлэхийн тулд бид БОНЗ-ын асуудал тус бүрийн бизнес болоод оролцогч талд үзүүлэх нөлөөг үнэлэх дөрвөн шатлалт процессын арга зүйг ашигласан. Үүнд, БОНЗ-ын стандартуудтай уялдуулсан дүн шинжилгээ, дотоод болон гадаад оролцогч талуудтай хийсэн ярилцлага, асуулт хариулт зэрэг багтсан болно.

Компанийн тогтвортой байдалд нөлөөлөх гол асуудлуудыг тодорхойлон үнэлэх нь БОНЗ-ын хамрах хүрээ, тогтолцоог бий болгох, сайжруулахад өндөр ач холбогдолтой байдаг. Өмнө дүрдсанчлан бид уг үнэлгээний үр дүнг компанийн БОНЗ-ын тогтолцоог оновчлох, энэ талаар олон нийтэд мэдээлэл түгээхэд ашиглах юм.

Үнэлгээний процесс

Нэгдүгээр ахлам:

Гадаад орчныг судалж материаллаг асуудлуудыг тодорхойлох

- Салбарын тайлагналд бенчмаркинг, харьцуулалт хийх
- Тэргүүлэх БОНЗ болон тогтвортой байдлын тайлагналын стандартуудыг судлах (SASB, GRI, TCFD гэх мэт)
- Салбарын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий БОНЗ-ын материаллаг асуудлуудыг тодорхойлох (байгаль орчны 5 асуудал, нийгмийн 7 асуудал, ажилтны 4 асуудал, засаглалын 10 асуудал)

Хоёрдугаар алхам:

Оролцогч талуудыг хамруулан үнэлгээний өгөгдлийг цуглуулах

- Менежментийн багийн гишүүдээс ярилцлага болон асуулгын аргаар өгөгдөл цуглуулах
- Компанийн нийт ажилтныг төлөөлөх түүврээс асуулгын аргаар өгөгдөл цуглуулах
- БОНЗ-ын хорооны захирлуудаас ярилцлага болон асуулгын аргаар өгөгдөл цуглуулах

Гуравдугаар алхам:

Материаллаг асуудлуудыг эрэмбэлэх


- Цуглуулсан өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх
- Материаллаг асуудлуудыг эрэмбэлэх

Дөрөвдүгээр ахлам:

Үр дүнг хэрэгжүүлэх

- Үр дүнг компанийн стратегид тусгах
- БОНЗ-ын тайлагналыг уялдуулж, оролцогч талуудыг хамруулах

2023 оны материаллаг байдлын үнэлгээний үр дүн



Товьёг: Байгаль орчин, Нийгэм, Засаглал Түвшин тус бүрд асуудлуудыг цагаан толгойн дарааллаар эрэмбэлэв.

Оролцогч талууд

Оролцогч талуудтай БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээг хийж, тогтмол уулзалт зохион байгуулахаас гадна и-мэйлээр харилцаж Юнител группийн үйл ажиллагаа, тогтвортой байдлын арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл солилцдог.

Оролцогч тал	Харилцдаг сувгууд	БОНЗ-ын хамааралтай асуудлууд
<p>Хэрэглэгчид Бид хэрэглэгчдэдээ найдвартай, аюулгүй, үнэ цэнтэй үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэдэг.</p>	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн судалгаа Үйлчилгээний салбар болон ажилтнууд И-мэйл, сошиал сувгууд 	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хаягдлын зохицуулалт Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал Үйлчилгээний хүртээмжтэй байдал Бүтээгдэхүүн үйлчилгээний аюулгүй байдал болон хариуцлагатай хэрэглээ Сүлжээний чанар, найдвартай байдал Хувийн нууц
<p>Хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид Үнэн зөв мэдээлэл солилцож, итгэлцэлд суурилсан харилцаа бий болгохыг эрхэмлэдэг.</p>	<ul style="list-style-type: none"> Биечлэн уулзах болон и-мэйл харилцаа холбоо Улирал тутмын тогтмол уулзалт 	<ul style="list-style-type: none"> БОНЗ-ын материаллаг бүх асуудал
<p>Ажилтнууд Бид ажилтнууддаа сэтгэл хангалуун ажиллах боломж бүрдүүлэхийг зорьдог</p>	<ul style="list-style-type: none"> Ажилтнуудыг хамруулсан санал асуулга Сайн дурын хөтөлбөрүүд И-мэйл, товхимол, Teams Удирдах түвшний ажилтнуудын уулзалт Багийн уулзалт, сургалт 	<ul style="list-style-type: none"> Ажилтны олон талт, тэгш байдал, оролцоо Ажилтны эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал Ажил горилогчийг татах, ажилтны оролцоог нэмэгдүүлэх, ажилтныг хадгалж үлдэх Хүний эрх
<p>Нийгмийн бүлгүүд Бид үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд хот суурин болон орон нутаг дахь нийгмийн бүлгүүдтэй хамтран ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> Ивээн тэтгэлэг, хандив Нийгмийг хамарсан арга хэмжээнүүд Сайн дурын арга хэмжээ, ажлын байрны нээлттэй өдөрлөгүүд Салбар холбоодын уулзалтууд Салбарын болон нийгмийн гишүүнчлэл, уулзалтууд Биечилсэн уулзалтууд 	<ul style="list-style-type: none"> Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал Олон нийтийн оролцоо ба хандив
<p>Нийлүүлэгчид Нийтлэг үнэт зүйл, тогтвортой байдлын зорилт бүхий нийлүүлэгчидтэй урт хугацаанд харилцан ашигтай хамтран ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> Нийлүүлэгчдийн бүртгэл Нийлүүлэгчдийн асуулга Ганцаарчилсан уулзалтууд Нийлүүлэгчийн үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал Бизнесийн ёс зүй, соёл Зохицуулалтын орчны нийцэл



БАЙГАЛЬ ОРЧИН

Бид хүрээлэн буй орчноо хамгаалж, ул мөрөө бууруулахад тохирсон тогтвортой байдлыг дэмжих шийдэл, хамтын түншлэл, орон нутгийн экологийн сайн сайхан байдлыг сайжруулах боломжийг эрэлхийлж байна.


- 1 Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал
- 2 Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент
- 3 Хог хаягдлын менежмент
- 4 Байгаль хамгаалал (Ногоон байгаасай)



Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал

Монгол Улсын эрчим хүчний гол түүхий эд, анхдагч эх үүсвэр бол нүүрс бөгөөд эрчим хүч үйлдвэрлэлийн явцад ялгарах хүлэмжийн хий нь манай орны байгаль, уур амьсгалын өөрчлөлтийг түргэсгэх томоохон шалтгаан болдог. Сүүлийн жилүүдэд түгээмэл тохиолдох болсон ган гачиг, зуд, ойн түймэр, үер усны аюул зэрэг давагдашгүй хүчин зүйлсийн давтамж нэмэгдэж байгаа нь үүнтэй холбоотой. Иймд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь бидний нэн тэргүүний асуудал болоод буй бөгөөд зөвхөн манай улсаар хязгаарлагдахгүйгээр дэлхий дахинаа хөндөгдөх сэдэв болжээ. Энэ утгаараа, орчин үед улс орнуудын засаг захиргаа болон хувийн хэвшил, бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа байгаль орчинд үчруулж буй сөрөг нөлөөгөө бууруулж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлагатай болоод байна.

Улс орны дэд бүтцийн хязгаарлагдмал байдал, чадварлаг боловсон хүчний хомсдол, эдийн засгийн тогтворгүй байдал зэргээс үүдэн эрчим хүчний эх үүсвэрээс нүүрс болон бусад чулуужсан түүхий эдийн хэрэглээг бүрэн халахад ихээхэн хөрөнгө шаардахын зэрэгцээ төдий хэмжээний эрсдэл дагуулна. Хэдий тийм ч Юнител групп нь хэрэглэгчдэдээ хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий харилцаа холбооны тасралгүй, найдвартай үйлчилгээгээ хүргэхдээ нүүрсстөрөгчийн үл мөрөө бууруулах, бус нутгийн эрчим хүчний дэд бүтцийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах зэрэг шийдлүүдийг тогтмол эрэлхийлж байгаа билээ.



Хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох

Хүлэмжийн хий буюу нүүрсхүчлийн хий (CO₂), метан (CH₄), азотын исэл (N₂O) зэрэг төрөл бүрийн хөргөлтийн хий нь нарны хэт ягаан туяаг өөртөө шингээж, температурыг өсгөн, дэлхийн дулаарлыг нэмэгдүүлж байдаг. Иймд хүлэмжийн хийн ялгарлаа оновчтой тооцоолж, бүртгэх нь бидний нэн тэргүүний хариуцлагатай ажил болоод байна.

Иймээс бид АНУ-ын БОХА-ийн олон улсын стандарт бүхий "Хүлэмжийн хийн ялгарлын факторуудын хаб"-ийн 2023 оны удирдамжийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлын тооцооллоо хянаж байна. Хүлэмжийн хийн тооллогод шууд буюу Хамрах хүрээ 1, шууд бус буюу Хамрах хүрээ 2-ын хүлэмжийн хийг хамрууллаа. Жишээлбэл, тог цахилгаан тасалдахад суурь станцуудыг эрчим хүчээр хангадаг дизель үүсгүүрүүд, компанийн автомашинуудын түлшний хэрэглээ зэрэг нь шууд үйл ажиллагаанаас үүдэлтэй бол CO₂, CH₄, N₂O зэрэг нь шууд бус үйл ажиллагаанаас үүдэлтэйд багтдаг. Ийнхүү нарийвчлан хэмжсэнээр бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрсстөрөгчийн талаар ойлголттой болохын зэрэгцээ сөрөг нөлөөг бууруулж ажиллахад илүү оновчтой болсон юм.

Эрчим хүчний зохицуулалт ба ялгарлыг бууруулах

Юнител группийн эрчим хүчний хэрэглээ нь нийт дөрвөн эх үүсвэртэй ба үүнд цахилгаан, дулаан, шатахуун, нарны сэргээгдэх эрчим хүч багтдаг. Эдгээрээс цахилгаан, дулаан, шатахуун нь чулуужсан түлшнээс шууд хамааралтай тул компанийн хүлэмжийн хийн ялгарлын ихээхэн хувийг эзэлдэг.

Иймээс бид сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ (ялангуяа нарны эрчим хүч) болон тоног төхөөрөмжүүдийнхээ эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн үндсэн хоёр стратегиар хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.



Хүлэмжийн хийн ялгарал ба бууруулалт	Нэгж*	2022	2023	Жил хоорондын өөрчлөлт
Нийт хүлэмжийн хийн ялгарал (Хамрах хүрээ 1 ба 2)	тонн CO ₂ e	12,964 ¹	14,494	12%
Хамрах хүрээ 1 ялгарал (шууд)	тонн CO ₂ e	488 ¹	700	43%
Хамрах хүрээ 2 ялгарал (шууд бус)	тонн CO ₂ e	12,476 ¹	13,794	11%
Ялгарахаас сэргийлсэн хүлэмжийн хийн тоо хэмжээ	тонн CO ₂ e	811 ¹	1,302	60%
Сэргээгдэх эрчим хүчээр	тонн CO ₂ e	794 ¹	1,280	61%
Эрчим хүчээ хэмнэхийн тулд шинэчилсэн тоног төхөөрөмж	тонн CO ₂ e	17 ¹	21	25%

Хүлэмжийн хийн ялгарлын эрчмийн харьцаа (Нийт хүлэмжийн хийг зохицуулсан петабайт датанд харьцуулсан харьцаа)

Нийт хүлэмжийн хийн ялгарал ба бууруулалт	Нэгж*	2022	2023	Жил хоорондын өөрчлөлт
Хүлэмжийн хийн ялгарлын эрчмийн харьцаа (Нийт хүлэмжийн хийг зохицуулсан петабайт датанд харьцуулсан харьцаа)	тонн CO ₂ e/PB	12.5	12.7	1%

¹ 2023 оны энэхүү тайланд хүлэмжийн хийн ялгарлыг тооцох факторуудыг шинэчилсэн тул 2022 оны үр дүнг дахин тооцоолсон болно.

* Тонн CO₂e эквивалент нь хүлэмжийн хийн ялгарлыг илэрхийлэх стандартчилагдсан нэгж бөгөөд энэ нь CO₂-оос бусад хүлэмжийн хийн ялгарлын тоо хэмжээ болон харгалзах дэлхийн дулаарлын потенциал (GWP100)-ын үржвэр байна.

Юнител группийн эрчим хүчний хэрэглээний 95 хувийг Дата төв болон суурин станцууд эзэлдэг тул бид энэ чиглэлд илүү анхаарч, хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах арга хэмжээнүүдийг авах нь зүйн хэрэг юм. Тиймээс 2022 он болон түүнээс өмнөх онуудад бид нарны эрчим хүчээр ажилладаг 216 суурин станцыг алслагдсан бүс нутгуудад байрлуулж, сүлжээний цар хүрээгээ өргөтгөсөн билээ.

Энэ мэтчилэн 2023 он гэхэд Юнител групп нь хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийх, урьдчилан сэргийлэх тал дээр онцлох ахицыг бий болгоод байна. Жишээлбэл нарны эрчим хүчний үйлдвэрлэлээ өмнөх оноосоо даруй 61 хувиар өсгөлөө.



1:5 Сэргээгдэх болон цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдсон суурь станцуудын харьцаа

8% Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь

Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт	Нэгж	2021	2022	2023	Жил хоорондын өөрчлөлт
Нийт эрчим хүчний хэрэглээ	ГЖ	107,608	153,780	176,914	15%
Үндсэн үйл ажиллагааны эрчим хүчний хэрэглээ	ГЖ	-	143,516	168,858	18%
Дэмжих үйл ажиллагааны эрчим хүчний хэрэглээ	ГЖ	-	10,264	8,056	-22%
Цахилгааны хэрэглээ (нэгдсэн сүлжээнээс ашигласан)	ГЖ	101,855	135,586	150,069	11%
Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ	ГЖ	5,753	8,705	14,031	61%
Шатахууны хэрэглээ	ГЖ	-	7,843	11,215	43%
Дулааны хэрэглээ	ГЖ	-	1,646	1,599	-3%
Эрчим хүчний эрчмийн харьцаа (нийт эрчим хүчний хэрэглээг зохицуулсан петабайт датанд харьцуулсан харьцаа)	ГЖ/ПБ	-	148	155	4%
Нийт цахилгаан эрчим хүчний хэмнэлт	ГЖ	-	188	162	-14%

* 2023 онд БОНЗ-ын хэмжих шалгууруудыг оновчлон тогтоосноор шатахуун болон дулааныг эрчим хүчийг нийт хэрэглээнд хамруулан тооцдог болсон.

Бидний жил бүр хэрэгжүүлдэг эрчим хүч хэмнэлтийн санаачилгууд “Эрчим хүчний зохицуулах хороо”-нд өгсөн амлалттай маань бүрэн уялддаг.

Тухайлбал, 2023 онд Дата төв болон суурин станцуудад ашиглаж байсан агааржуулалтын болон цахилгаан зохицуулалтын 17 хуучин төхөөрөмжийг халж, эрчим хүчний хэмнэлт бүхий төхөөрөмжөөр сольж шинэчилсэн. Мөн Централ Тауэрийн төв оффисыг засварлахдаа эрчим хүчинд хэмнэлттэй ЛЕД гэрлүүдийг суурилуулж, нэгдсэн гэрлийн унтраалгуудыг хэсэгчилсэн хэлбэрт шилжүүлсэн билээ. Ингэснээр цахилгаан эрчим хүчний 65 МВтц (233.6 ГЖ) -ийн хэмнэлтийг бий болгосны зэрэгцээ 21 тонн CO₂e хүлэмжийн хийн ялгарал үүсэхээс сэргийлж чадсан байна. Цаашилбал, бид 2023 онд авч хэрэгжүүлсэн эрчим хүч хэмнэлтийн санаачилгуудын үр дүнд жил бүр 136 МВтц (490 ГЖ) эрчим хүчийг хэмнэж, 45 тонн CO₂e ялгарахаас сэргийлэх тооцоолол гаргаад буй.

Бид дараагийн жилүүдэд ногоон ирээдүйн төлөөх нэгдмэл зорилготой хувь хүн, ААН-үүдтэй хамтран ажиллахыг эрхэмлэж буй. Мөн эрчим хүчийг үр ашигтай ашиглахад чиглэсэн сургалт, контентууд бүтээж, түүгээрээ дамжуулан нийт ажилтныхаа дунд тогтвортой хэрэглээний соёлыг бий болгоно.

1.6% ↑

2022 онд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ 6.4% байсан бол 2023 онд 8% болж өсөв

8.3% ↓

Централ Тауэрт байрлах төв оффисын засварын үр дүнд цахилгаан эрчим хүчний хэрэглээ буурав

3 жил

Централ Тауэрт байрлах төв оффис “Эрчим хүчинд хамгийн хэмнэлттэй түрээслэгч”-ээр гурван жил дараалан тодров

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент

Өдрөөс өдөрт технологийн салбар хувьсан, шинэчлэгдэж байгаа өнөө үед хүмүүсийн хэрэглээнээс үүсэлтэй электрон хаягдлын хэмжээ үлэмж хэмжээгээр нэмэгдсээр аюулын түвшинд ойртож ирээд байна. Уг асуудалд дэлхийн томоохон харилцаа холбооны компаниуд учирч болох эрсдэлийг бууруулахын тулд, нөгөөтээгүүр нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэхийн тулд бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай тулгараад байна.

Монгол Улсын хувьд электрон хог хаягдлын менежмент гэдэг нь өмнө нь яригдаж байгаагүй шинэ сэдэв. Хэдийгээр хуулийн хүрээнд электрон хаягдал нь аюултай хог хаягдлын ангилалд багтдаг хэдий ч уг асуудалд чиглэсэн дорвитой ажил хийгдээгүй хэвээр байна. Учир нь зохистой боловсруулалт хийх дэд бүтэц байгаагүй ба иргэдийн дунд ч энэ талаарх

мэдлэг, мэдээлэл тун хомс. Иймд бид электрон хог хаягдлыг дахин боловсруулахын тулд энэ талаарх ойлголтыг түгээж, үндэс суурийг нь зөв тавьж, системчилсэн арга зам, тогтвортой менежментийг бий болгоход анхаарч байгаа билээ. Тэр ч утгаараа холбогдох салбар, салбарын аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах үйл явцыг эхлүүлээд байна.



Юнивишн IPTV төхөөрөмж болон “ашиглалтын мөчлөгийн төгсгөлийг” удирдах нь

Юнивишнийн IPTV төхөөрөмж нь 2011 оноос Linux үйлдлийн системээр ажиллаж ирсэн бол өнгөрсөн онд Android үйлдлийн системтэй болж шинэчлэгдсэн. Учир нь уг төхөөрөмжийн хүчин чадал орчин үеийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэхгүй болсноос гадна аливаа гэмтэл доголдол гарсан тохиолдолд үйлдвэрлэгч* талаас хариуцах боломжгүй болсон тухайгаа бидэнд мэдэгдсэн юм.

Иймд 12 жилийн турш ашигласан Linux үйлдлийн системээ халж, Android үйлдлийн систем бүхий “Univision 4.0” дэвшилтэд төхөөрөмжийг зах зээлд нэвтрүүлсэн. Хуучин төхөөрөмж ашиглалтаас гарснаар хэрэглэгч айл өрхүүдэд электрон хог хаягдал хуримтлагдах нөхцөл үүсэж, Юнивишнийн зүгээс уг асуудалд шийдэл хайж эхэлсэн юм.

Энэ бүхнээс улбаалан Юнител групп нь байгальд ээлтэй, тогтвортой үйл ажиллагааг дэмжих үүднээс бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн төгсгөлийн менежментийг хариуцлагатайгаар хэрэгжүүлж, Юнивишнийн хуучин төхөөрөмжүүдийг эргүүлэн татах ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд бид хэрэглэгчидтэйгээ тодорхой хэмжээнд хамтарч ажиллах шаардлага гарсан нь ашиглалтаас гарсан хуучин төхөөрөмжийг өөрт ойр байрлах Юнителийн салбарт буцааж өгөх явдал байв. Эсвэл шинэ төхөөрөмж гэртээ суурилуулах үедээ үйлчилгээний ажилтанд хуучин төхөөрөмжөө буцаан өгч явуулах замаар айл өрхүүдэд хуримтлагдах байсан электрон хог хаягдлыг тодорхой хэмжээнд бууруулсан билээ.

- Электрон хог хаягдлыг бууруулахдаа анхаарах чухал нэг зүйл нь тухайн төхөөрөмжөөс гарч болох байгальд хортой бодисууд юм. Жишээлбэл: Бүрдэл хэсгүүд болох зэс, цагаан тугалга, төмөр, алт, титан, хөнгөн цагаан, хуванцар зэргүүд нь химийн нэгдлийг агуулдаг бөгөөд биологийн задралд орох хугацаа асар их. Задралд ороход олон мянган жил зарцуулдаг ба ингэхдээ хүний амин хэрэгцээ болох ус, хөрсийг бохирдуулах өндөр эрсдэл дагуулна. Үүнээс гадна хэрэв уг хэсгүүдийг ил задгай шатааж устгавал агаарт хортой дэгдэмхий нэгдлүүдийг тараадаг. Энэ бүх аюулаас сэргийлж цугларсан электрон хаягдлыг ялгахдаа бид “тойрог” арга барилыг ашиглах буюу дахин боловсруулах замаар ажиллахаар шийдсэн.

17,380

ширхэг төхөөрөмж буцаан цуглуулсан



2,283кг
хуванцар



1,435кг
эх хавтан

Нийт
3,718кг



* Юнивишнийн үйлчилгээнд ашиглагддаг бүх төхөөрөмжийг гуравдагч талын үйлдвэрлэгчид нийлүүлдэг.

Юнивишнийн төхөөрөмжийг урт хугацаанд, найдвартай засвар үйлчилгээг нь хариуцаж ирсэн “Эко Вэйст” ХХК нь бидний итгэлт түнш байгууллага юм. Энэхүү компани нь хуучин төхөөрөмжүүдийг гаднах хуванцар болон эх хавтан гэх хоёр төрлийн эд ангиар нь задалж, ялгадаг. Ялгасан эх хавтангаа электрон барааны засварын сэлбэг болгохоор авч үлддэг ба гаднах хуванцар хэсгийг дараагийн дамжлага руу шилжүүлнэ.

■ Төслийн зорилго:

Ашиглалтаас гарсан

14,000 ширхэг төхөөрөмжийг дахин боловсруулна


■ Төслийн явц:

7,119 ширхэг төхөөрөмжийг дахин боловсруулсан

→ зорилгын **51%**

964кг бүхий гаднах хуванцар бүрхүүлийг дахин боловсруулсан

621кг бүхий эх хавтанг дахин ашиглахаар хадгалуулсан



Юнивишнийн электрон хаягдлыг боловсруулах энэхүү төсөлд бусад компаниуд сайн дурын үндсэн дээр, өөрсдийн нийгмийн хариуцлага, тогтвортой байдлын зорилтын дагуу хамтран ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Төслийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангах үүднээс бид бүхэн хуучин төхөөрөмжүүдийг “Эко Вэйст” ХХК-д хүлээлгэн өгч, уг төхөөрөмжүүдтэй холбоотой мэдээллийг ямагт солилцон, хамтран ажиллаж байна.

Дашрамд дурдахад энэхүү төсөл нь Монгол Улсад электрон хог хаягдлыг амжилттай боловсруулсан анхны төсөл юм. Бид олон төрлийн боломжит шийдлүүдийг түршиж, олон байгууллагуудтай хамтарч ажилласны эцэст өөрсдийн хэрэглэгчдээс цуглуулсан хуучин төхөөрөмжийн хуванцар эдийг амжилттай дахин боловсруулж чадлаа.

Ингээд ялгагдсан хуванцар хэсгийг бид “MCS Property” компани болон тэдний байнгын итгэлт түнш болох “Хэв Хашмал” ХХК-д шилжүүлнэ. “Хэв Хашмал” нь Монголын барилгын салбарт танигдсан, барилгын дагалдах бараа материалын томоохон үйлдвэрлэгч юм. Бидний цуглуулан өгсөн хуванцар хэсгийг уг компани үйлдвэрийн аргаар хайлуулан барилгын арматурын ивүүр болгох үйл ажиллагааг хариуцан ажилласан. Ивүүр гэдэг нь барилга угсралтын явцад бетон цутгахын өмнө арматурыг газраас хөндийрүүлэн барьж байх зориулалттай хуванцар хэрэгсэл юм. Бэлэн болсон ивүүрийг MCS Property компани нь өөрсдийн бүтээн босгож буй барилгын төслүүд дээр амжилттай ашиглаж байна.



Юнивишнийн электрон хог хаягдлыг дахин боловсруулах үйл явц

Сонирхолтой баримт:



Одоогоор дахин боловсруулалтад оруулсан **739кг** хуванцрыг ашиглан **73,900** ширхэг хүртэлх арматурын ивүүр үйлдвэрлэх боломжтой ба ийм тооны ивүүрээр **6,500 м²** барилгын талбайд (хөл бөмбөгийн стандарт талбайн 9/10 орчим) ашиглаж болохуйц хэмжээний тоо юм.



Гаднах хуванцрыг өөр эд материалтай холих замаар арматурын ивүүрийг үйлдвэрлэдэг. Дээрх тооцоолол нь өөр эд материалтай холихгүйгээр үйлдвэрлэх хийсвэр нөхцөлд тулгуурласан болно.

'No E-waste' кампанит ажил

Электрон хог хаягдлыг дахин боловсруулах ажлын үр дүн нь Юнивишнийн хэрэглэгчдээс шууд хамаарч байсан учраас хэрэглэгчдээ мэдлэгжүүлэх, үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор "No E-Waste" кампанит ажлыг эхлүүлсэн* юм.

'No E-Waste' кампанит ажил маань дараах гурван үндсэн бүрэлдэхүүнтэй:

- 1 Мэдээлэл түгээх:**
Байгаль орчны хамгаалал, хог хаягдлын менежментийн тухай салбарын мэргэжилтнүүдтэй хамтарч, олон нийтэд электрон хаягдлын тухай суурь мэдлэг олгох
- 2 Уриалах:**
Хэрэглэгчдийг IPTV-ийн хуучин төхөөрөмжүүдээ буцаан өгснөөр электрон хог хаягдлыг бууруулж болох талаар уриалан дуудах
- 3 Үр дүнг танилцуулах:**
Хэрэглэгчдийн буцаан өгсөн төхөөрөмжүүдийг бид хэрхэн, ямар арга замаар дахин боловсруулж буйг мэдээлэх

Бид энэхүү кампанит ажлаар дамжуулж хог хаягдлын менежментэд чиглэсэн энэ төрлийн чухал ажлуудад хүмүүсийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн дунд байх электрон хаягдлын талаарх ерөнхий ойлголтыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн.



Хуучин төхөөрөмжөө дахин боловсруулалтад өгөөрэй

Суурилуулалтын ажилтанд хуучин төхөөрөмжөө буцаан өгч,
байгаль дэлхийгээ хайрлаарай

*Энэхүү кампанит ажил нь 2023 оны 11-р сард эхэлсэн бөгөөд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар үргэлжилж байна.

Дараагийн алхмууд

2023 онд бид бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн төгсгөлийн менежментийг хэрэгжүүлэн, анхны суурь алхмуудыг амжилттай тавилаа. Цаашдаа энэхүү менежментийн үйл ажиллагааг урт хугацаанд, илүү тогтвортой байлгах үүднээс компанийн үндсэн бодлого, стандартад нийцүүлэх шаардлагыг баримтлан ажиллана. Мөн ирэх жилүүдэд бид шинэ төсөл, санаачилгуудыг хэрэгжүүлэн ажиллах зорилготой байна.



Хог хаягдлын менежмент

Юнител групп байгаль орчинд ээлтэйгээр үйл ажиллагаагаа явуулах зорилгынхоо хүрээнд Дата төв, агуулахын байр, оффисууддаа аюултай болон хатуу хог хаягдлыг ангилж байна. Бид хаягдлын менежментийг нэгдсэн байдлаар журамлаагүй ч гуравдагч байгууллагуудтай хамтран технологийн шийдэл ашиглан байгаль орчинд ээлтэй аргуудыг байгууллагадаа нэвтрүүлээд байгаа юм. Мөн хаягдлаа

багасгах, хаягдал материалыг дахин ашиглах, боловсруулах байдлаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулан, нөөцөө хэмнэхийг зорин ажиллаж байна.



-10°C хэмээс доош температурт, нарны эрчим хүчээр ажилладаг станцуудын хувьд:



Энгийн байртай станцуудын батарей ихэвчлэн 2 ЖИЛ ажилладаг



Пассив барилгатай станцуудын батарей 4 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ ажиллах боломжтой

Үйл ажиллагааны хог хаягдал

Манай улсад хог хаягдлыг дахин боловсруулах дэд бүтэц хангалттай хэмжээнд хөгжөөгүй учир компанийн төвийн сервер болон суурин станцуудаас үүссэн хаягдлаа бид агуулах байрандаа хуримтлуулдаг. Тиймээс үүссэн хог хаягдлыг багасгах зорилгоор төхөөрөмж болон бусад материалуудын ашиглалтын хугацааг уртасгах арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ нь хог хаягдлын асуудлуудыг шийдэж байгаа төдийгүй ашиглах нөөцийг оновчтой зохицуулах эерэг нөлөөтэй юм.

Нарны станцууд дээрх пассив барилгууд
Бид сэргээгдэх эрчим хүчийг ашиглан алслагдсан газруудад сүлжээгээ өргөтгөх зорилгоор нарны станцуудыг байгуулсан бөгөөд тус станцуудын батарейн ашиглалтын хугацааг уртасгахад анхааран ажиллаж байна.

Нарны батарей нь хар тугалга, лити, кадми зэрэг хортой хүнд металлуудыг агуулдаг

тул бид станцуудын засвар, үйлчилгээг хийхдээ ирээдүйд үүсэж болзошгүй аюултай хог хаягдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа юм.

Радио сүлжээний тоног төхөөрөмж болон батарейг хэвийн нөхцөлд ажиллуулах нь ашиглалтын хугацааг уртасгаж, сүлжээний найдвартай байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс бид пассив барилгуудыг байгуулсан бөгөөд тус пассив барилга нь Монгол орны эрс тэс уур амьсгалтай тогтворгүй цаг агаарын нөхцөл байдлаас төхөөрөмжийг хамгаалж, тэр дундаа батарейн ажиллах орчны температурыг тогтворжуулахад чухал нөлөө үзүүлж байгаа юм. Ингэснээрээ батарейн ашиглалтын хугацааг хоёр дахин уртасгаж нарны системийн үр ашгийг ч мөн нэмэгдүүлж чадаж байна.

Бид нарны эрчим хүчээр ажилладаг станцуудад 2023 онд бүрэн хэмжээний

үзлэг хийн хуучирсан барилгуудыг илрүүлж 5 станцын барилгыг пассив болгон шинэчилсэн билээ. Цаашид нарны эрчим хүчээр ажилладаг станцуудын байрны насжилт болон бат бөх чанарыг харгалзан үзэж 10-аас дээш жил болсон барилгуудыг шинэчлэхээр төлөвлөөд байна.



Оффисын хог хаягдал

Бид оффисын өдөр тутмын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зохицуулахдаа 3R (Reduce, Reuse, Recycle) зарчмыг баримталдаг. Уг зарчмыг өдөр тутамдаа хэрэгжүүлснээр байгууллагын ажилтнууддаа байгальд ээлтэй, зөв дадал зуршлыг төлөвшүүлж чадна хэмээн итгэж байна.

Дахин боловсруулах (Recycle)

Бид төвлөрсөн оффисууддаа хог ангилан хаях цэгтэй болсон бөгөөд ингэснээрээ ажилтнууддаа хогоо ангилан хаях зөв дадлыг суулгах төдийгүй ил задгай хаягддаг хаягдлын хэмжээг бууруулахад чухал түлхэц болж байгаа юм. Түүнчлэн оффис түрээслүүлэгч байгууллагын хог хаягдлын менежмент хог ангилан хаях ажлын үр дүнд шууд нөлөөлдөг учир бид оффис бүрийн нөхцөл байдлыг тус тусад нь үнэлэн оффис бүрд тохирсон шийдэл боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийн дагуу бид Дата төв болон агуулахын байрныхаа гадаа талбайд хог хаягдал ангилах цэгүүдийг бий болгосон юм. Мөн байгууллагын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг устгах, дахин боловсруулахдаа бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



2023 онд: Бид Дата төв болон агуулахын байранд хуримтлагдсан **650кг** хаягдлыг гуравдагч байгууллагаар дамжуулан дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн.

650кг хог хаягдал



508кг
картон



88кг
хуванцар сав



54кг
гялгар уут

Сонирхолтой баримт:

Дата төв дээр хуримтлагдсан хаягдал картоныг дахин боловсруулж хайрцаг болон архивын бор хавтас үйлдвэрлэдэг.



Манай байгууллагын төв оффис байрладаг Централ Тауэр нь хог хаягдлын нэгдсэн зохицуулалттай бөгөөд бид байгальд ээлтэй байх зорилгынхоо хүрээнд хогоо ангилж хаях, дахин боловсруулах үйлдвэр рүү явуулах байдлаар нэмэлт зохицуулалт хийн ажиллаж байна.

Бид Централ Тауэр дахь цэвэрлэгээ үйлчилгээг хариуцдаг Юнисервис Солюшн ХХК-тай хамтран дахин боловсруулах боломжтой PET хуванцар савыг ангилан

ялгах ажлыг санаачлан хэрэгжүүлж байна. Ингэснээр тус байгууллага нь манай оффисууд дээр цугларсан PET хуванцрыг TML Plastic дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгч байгаа юм. Бид энэхүү санаачилгаа цаашид үр дүнтэйгээр хэрэгжүүлэх зорилгоор PET хуванцрыг зөв ангилан хаях, хуванцар савыг хэрхэн дахин боловсруулдаг талаарх сургалтыг ажилтнуудынхаа дунд зохион байгуулж байна.

Оффисын хог хаягдал

Бид оффисын өдөр тутмын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зохицуулахдаа 3R (Reduce, Reuse, Recycle) зарчмыг баримталдаг. Уг зарчмыг өдөр тутамдаа хэрэгжүүлснээр байгууллагын ажилтнууддаа байгальд ээлтэй, зөв дадал зуршлыг төлөвшүүлж чадна хэмээн итгэж байна.

Дахин ашиглах (Reuse)

Юнител группийн оффисын ажилтнуудын ашиглахаа больсон компьютер, принтер зэрэг тоног төхөөрөмжүүд жил бүр актлагдан, цахим хаягдал болон гардаг. Бид ажилтнуудынхаа компьютерыг 5 жил тутамд сольдог ба хэрэв тухайн компьютер нь шаардлага хангахгүй болсон бол үүнээс ч өмнө солих тохиолдлууд бий. Бид актлагдсан компьютерууд дахь файлуудыг авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангасны дараа тухайн компьютеруудыг хөнгөлөлттэй үнээр ажилтнууддаа санал болгох эсвэл зорилтот байгууллагуудад хандивлах зэрэг дахин ашиглах тал дээр анхаарч байна.

Бууруулах (Reduce)

Бид 2023 онд төв болон бүсийн оффисууд дахь олон жижиг принтерүүдийг өндөр хүчин чадалтай нэг принтерээр сольсон. Үүний үр дүнд оффисын цаасны хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 26 хувиар буурсан байна. Харин энэ онд бид цаасны зохистой хэрэглээний талаар зөвлөмж боловсруулан ажилтнууддаа зааварчилгаа хүргэхээр ажиллаж байна. Үүнд: бичгийн цаас, нэрийн хуудас, албан бланк, дугтуй зэрэг багтана.

Байгууллагын ажилтнуудынхаа нэг удаагийн хэрэглээг бууруулахын тулд бид бүх оффистоо "Нисдэг кофе" буюу өөртөө үйлчлэх кофены автомат машин байрлуулсан. Энэхүү автомат машины кофе нь кофе шопуудын борлуулдаг үнээс харьцангуй хямд бөгөөд ажилтнууд өөрийн аягандаа кофегоо хийж уудаг нь нэг удаагийн цаасан аяганы хаягдлыг бууруулж байгаа юм.



Зорилтот байгууллагуудад хандивлах

Unitel HUB төвүүдэд ашиглах

Ажилтнуудад хөнгөлөлттэй үнээр санал болгох



Нэг удаагийн цаасан аяганы хэрэглээг 15,344 ширхгээр бууруулж

153кг

цаас хэмнэсэн**




Бид цаасны хэрэглээгээ бууруулснаар

762кг


цаас хэмнэсэн*

*Энэхүү тооцооллыг 2022 болон 2023 оны цаасны хэрэглээний зөрүүг нэгж бүтээгдэхүүний жинд үржүүлэн гаргасан болно
**ТЭнэхүү тооцооллыг "Нисдэг Кофе" автомат машины борлуулалтын тоог ижил төрлийн бүтээгдэхүүний жинд үржүүлэн гаргасан болно



Үйлчилгээний хог хаягдал

Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ цахимжуулах нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм. Бид 2023 онд анхны дижитал салбараа нээсэн ба хэрэглэгчид нэгж, дата авах, төлбөр төлөх зэрэг үйлчилгээг илүү хялбараар, дижитал төхөөрөмжүүдийг ашиглан авах боломжтой болсон юм. Түүнчлэн бид шинэ хэрэглэгчидтэй хийх гэрээг цахимжуулан, 1'500, 2'000₮-ийн нэгжийн карт болон баяруудаар хэвлэн гаргадаг тусгай картуудаа дижитал хэлбэрт шилжүүлснээр цаасны хэрэглээгээ багасгаж чадсан.



**Үүсэж болох хаягдлын жинг ижил төрлийн бүтээгдэхүүний жингийн мэдээлэлд үндэслэн тооцоолсон болно*



Байгаль хамгаалал (Ногоон байгаасай)

Хүн төрөлхтний эх дэлхийгээ хайрлан хамгаалах нэгдмэл үзэл санаа, хамтын ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд эергээр нөлөөлөхөд чухал үүрэгтэй. Тиймдээ ч Юнител групп нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээрээ дамжуулан хүрээлэн буй орчиндоо эерэг өөрчлөлт авчрахын зэрэгцээ тогтвортой хөгжлийн төлөөх хүн бүрийн оролцоог тодорхой хувиар нэмэгдүүлэхийг эрмэлздэг билээ. Энэ утгаараа бид "Ногоон байгаасай" уриан дор байгаль орчин, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлж буй төслүүдийнхээ цар хүрээ, хүртээмжийг тэлсээр байна. Энэ мэтчилэн олон талт оролцоог бий болгож, Монгол Улсад нийгмийн сайн сайхны төлөөх нэгдмэл үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь компанийн маань ч эрхэм зорилгуудын нэг билээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах

Юнител группийн инженерүүд алслагдсан сумдад суурин станц угсрах, засварлах явцдаа усны нөөц хомс газар нутагт зэрлэг амьтад харангадаж, хүнд нөхцөл байдалд байгааг анзаарсан юм. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, ган гачгийн давтамж ихэссэнээс гадна говь нутгийн байгалийн онцлог, жилд орох хур тунадасны хэмжээ бага байдагтай холбоотой.

Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд 2021 онд Юнител группийн нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хэлтсээс санаачлан тусгай хамгаалалт бүхий алслагдсан, усны нөөц хомс газруудад "хөв" цөөрөм байгуулах ажлыг эхлүүлсэн. Байгалийн чулуу, чулууны цавуу, үл нэвчүүлэх геомембранаас бүрдэх энэхүү хиймэл цөөрөм нь хур тунадсыг цуглуулж барьснаар зэрлэг амьтдын найдвартай ундны усны эх

үүсвэр болдог давуу талтай. Ийнхүү амьтдын амьдрах орчныг сайжруулах, экологийн тэнцвэрт байдлыг сэргээх нь манай компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй чухал ажлуудын нэг болсон юм.

2023 онд бид Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран тусгай хамгаалалт бүхий 10 газарт нийт 16 хөв цөөрмийг барьж байгуулсан. Говь-Алтай аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэдээлснээр 2022 онд байгуулсан хөв цөөрмийн нэг нь ойр орчмынхоо нийт амьтдын 30 хувийг буюу нэг жилд ойролцоогоор 3,000 амьтныг ундаалж чадсан гэх тооцоолол бий. Мөн энэхүү санаачилга нь усны нөөц хомс бүс нутагт амьдардаг цоохор ирвэс, мазаалай,

янгир зэрэг Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг (ОУБХН)-ийн Улаан номд орсон амьтдыг амьд үлдэхэд чухал нөлөөтэйгөөрөө онцлог юм.

Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд бид энэхүү ажлаа Юнителийн албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээ (Facebook, Twitter), нөлөөлөгч (Хөдөөний айл), мэдээллийн агентлаг (ikon.mn, Gogo.mn) зэрэг төрөл бүрийн сувгуудаар дамжуулан мэдээлээд буй. Түүнчлэн хөв цөөрөм барих заавар бүхий бичлэгийг олон нийтэд хуваалцсан нь хариуцлагатай аяллын талаар боловсрол олгоод зогсохгүй хүн бүр энэ чиглэлд өөрсдийн шинэ санаагаа хөгжүүлж, ажил хэрэг болгоход нь урам зориг өгөхийг хүссэн билээ.



Уг санаачилгын хүрээнд 2021 оноос хойш
23 ХӨВ ЦӨӨРӨМ баригдсан

Олон нийтийн оролцоо

Байгаль хамгааллын чиглэлд бидний жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг санаачилгуудын нэг бол нийт ажилтнаараа мод тарих арга хэмжээ юм. Тус ажлыг Нийслэлийн Байгаль орчны газраас дэмжиж, мод тарих газар болон цаашид арчилж хамгаалах асуудалд хамтарч ажиллахаар 2022 онд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан билээ.

Одоогоор бид Чингэлтэй дүүрэг дэх Хайрхан хөгжлийн төвийн талбайд мод тарих өдөрлөгөө хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулаад буй. Энэхүү үйл ажиллагаанд 240 ажилтан оролцож, 5-6 сарын настай 3,000 хайлаасны үрсэлгээг авч тарьсан. Ингэхдээ “Ногоон

хөгжлийн төлөө ногоон гэрлээр хамтдаа” ТББ-ын мэргэжлийн заавар зөвлөмжийг баримталж, хөрсний бүтэц, шинж чанартаа тохируулан уг модны үрсэлгээг сонгосон билээ. Мөн тус байгууллагууд нь 2024 оныг дуустал моднуудын ургалтын явцыг шалгах, услах, шаардлагатай бордоогоор бордох зэрэг тогтмол арчилгааг хариуцахаар гэрээ байгуулан ажиллаж буй. Ингэснээр бид тарьсан моднуудынхаа ургацыг эрчимжүүлэхээс гадна экосистемд үзүүлэх эерэг нөлөөллийг нь урт хугацаанд нэмэгдүүлэх боломжтой юм.

2023 онд



Мод тарихад
240

АЖИЛТАН
оролцсон



Мод тарих үйл
ажиллагаанд ажилтнуудын

12.7%
оролцсон*



Уг санаачилгын хүрээнд
2021 оноос хойш

6,000

МОД
тарьсан

*2023 оны гуравдугаар
улирлын байдлаар



Түүнчлэн бид байгаль орчны бохирдлын асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор Дэлхийн цэвэрлэгээний өдрийг тохиолдуулан жил бүр Түүл гол болон эргэн тойрныг нь цэвэрлэдэг. Энэ жилийн хувьд тус үйл ажиллагааг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан бөгөөд Түүл голын сав газрын захиргаа биднийг дэмжиж, компанийн ажилтнуудаас маань гадна сайн дурын ажилтнууд оролцсон билээ. Нийт 7,500 гаруй сайн дурын ажилтан Түүл голын дагуух Дунд гол, Бэлх гол, Улиастайн гол, Зайсангийн гүүр, Маршалын гүүр, Баянзүрхийн гүүр зэрэг байршлуудад хуваарилагдан ажилласан. Ингэхдээ тус сав газрын 110км-



1,000

ТОНН ХОГ ХАЯГДАЛ
Түүл голын эрэг дагуу цэвэрлэсэн



7,500


САЙН ДУРЫН АЖИЛТАН
цэвэрлэгээнд оролцсон

т багтах 3,200га талбайг цэвэрлэж, 1,000 гаруй тонн хог хаягдлыг түүснээр маш чухал экосистемийг сэргээж чадсан. Юнител групп байгаль дэлхийгээ хамгаалах, түүнийг нөхөн сэргээхийн төлөөх ажлаа ийнхүү түүштэй үргэлжлүүлсээр байна.

НИЙГЭМ

Харилцаа холбооны тэргүүлэгч компанийн хувьд бид нийгэмд үзүүлэх үр нөлөөг өргөн хүрээнд авч үзэхийг хичээдэг. Ингэхдээ цахим хуваагдлыг бууруулж, хүртээмжтэй ажлын орчныг бүтээн, хариуцлагатай нийлүүлэлтийн гинжин хэлхээг нэвтрүүлэх алхмуудыг хэрэгжүүлж байна.

- 1 Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
- 2 Ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллах нөхцөл, сайн сайхан байдал
- 3 Ажилтнуудын тогтвор суурьшил, идэвх оролцоо
- 4 Нийгэмд тустай ажлууд
- 5 Цахим хуваагдлыг бууруулах ажлууд
- 6 Нийлүүлэлтийн хэлхээний менежмент



Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал

Юнител групп нь шударга, хүртээмжтэй нийгмийг бүтээхийн тулд олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдлыг дэмжин ажилласаар ирсэн. Бид хувь ажилтан бүрийн ондоошлыг эергээр хүлээн авч цаашлаад олон талт байдлыг бий болгосноор аливаа асуудалд шинийг эрэлхийлэх, санаа бодлоо уралдуулах, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үздэг. Энэ нь компанийн тэгш эрхт соёлыг бүрдүүлж өгөхөд нэн тустай.

Бидний хувьд олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдлыг дэмжин ажиллах нь дараах давуу талуудыг бий болгодог. Жишээ нь: ажилтан бүр өөрийгөө бүрэн дайчлах, ажлын байр дээрээ тав тухтай, сэтгэл амар ажиллах, цаашид өсөн дэвших бололцоог бүрдүүлэх, мөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэх мэт.


Юнител групп нь 2022 онд ялгаварлан гадуурхал болон аливаа дарамт шахалтыг цээрлэх, хүн бүрийн эрх тэгш байдлыг хангах, ажилтнуудын

дунд найрсаг харилцааг бий болгох зэрэг үндсэн зорилтуудыг тусгасан Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдлыг дэмжих журам баталсан. Бидний үндсэн зарчим бол хувь хүн бүрийн үнэ цэнийг хүндэтгэж, нас, хүйс, үндэс угсаа, соёлын онцлог, тусгай хэрэгцээт эсэх, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, амьдралын туршлага, нийгэм эдийн засгийн байдлаас үл хамааран хүн бүрд тэгш боломж олгох явдал юм.

(Юнител группийн олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдлыг хангах стратегийн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл **2022 оны Тогтвортой байдлын тайлан** → **Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдал** холбоос руу хандана уу.



2023 оны Юнител группийн ажилтнуудын хүн ам зүйн задаргаа



Хүйсийн тэгш харьцаа

Бид удирдах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн манлайллыг үргэлж дэмждэг. Мөн тэдний ажлын байранд эзлэх орон зайг зорилтод хувиас дээш байлгахыг эрмэлздэг билээ.

Удирдлагын түвшин	Эмэгтэйчүүдийн зорилтот %	Эмэгтэй*	Эрэгтэй*
Менежментийн баг	35.0%	40.0% (↑)	60.0% (↓)
Өргөтгөсөн менежментийн баг	50.0%	50.4% (↓)	49.6% (↑)

*Тайлбар: (↑) 2022 оноос өссөн; (↓) 2022 оноос буурсан

Тусгай хэрэгцээтэй хүмүүст зориулсан ажлын байр

Бид 2023 онд тусгай хэрэгцээт иргэдийг дэмжих зорилгоор тэдний ажиллаж болохуйц ажлын байрны тоог хэрхэн нэмэгдүүлэх тухай судалсан билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид тусгай хэрэгцээт иргэдэд тохируулсан ажлын байрны үнэлгээ* хийлгэхийг зорьж, гуравдагч байгууллагатай хамтран ажилласан. Үнэлгээний явцад тухайн үед ажиллаж байсан тусгай хэрэгцээт ажилтнуудын эрүүл мэнд, ажиллах орчин, ажлын цаг болон харилцаа хандлагыг судаллаа. Уг судалгаанаас эдгээр ажилтнуудад тулгараад буй асуудлыг олж илрүүлэх, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх тухай арга замудыг олж тогтоосон. Үр дүнд нь бид тусгай хэрэгцээт хүмүүсийн ажиллах боломжтой дөрвөн ажлын байрыг тодорхойлсон юм.

Тусгай хэрэгцээт үндсэн ажилтнуудын тоо: **6**

Бид Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нийт ажлын байрныхаа дөрвөөс доошгүй хувьд тусгай хэрэгцээт иргэдийг ажиллуулахын тулд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран гишүүдээс нь гэрээт үйлчилгээ авч байна.


Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран ажиллаж буй тусгай хэрэгцээт ажилтнуудын тоо: **69**

* Судалгаанд хамрагдсан хүмүүст урьдчилан мэдээлэл өгч, зөвшөөрөл авсан ба оролцогчдын нууцлалыг чандлан хадгалж, цуглуулсан мэдээллийг зөвхөн судалгааны зорилгоор ашигласан.



Газарзүйн байдал

2023 онд Юнител групп Дархан хотод хэрэглэгчийн үйлчилгээний төвөө нээж, шинээр 60 гаруй ажлын байрыг бий болголоо. Цаашдаа бид орон нутгийн хөгжлийг илүү дэмжих зорилгоор салбар нэгж болон үйл ажиллагааны төвүүдээ бусад аймгуудад байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү үйл ажиллагаа нь үе шаттайгаар хэрэгжихийн зэрэгцээ бид өөрсдийн үнэнч хэрэглэгчдэдээ илүү ойртож, хүртээмжтэй цогц үйлчилгээг хүргэхээр ажиллаж байна.



Ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллах нөхцөл, сайн сайхан байдал

Бид ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд анхаарснаар ажилтан осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөхгүйгээр ажлаа гүйцэтгэж байна. Эрүүл, аюулгүй ажлын орчин бүрдүүлэх нь бидний бизнесийн ёс зүйтэй нийцдэг бөгөөд энэ нь өрсөлдөөнт зах зээлд хариуцлагатай ажил олгогч байхад чухал нөлөө үзүүлж байгаа юм.

Юнител групп нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2023 онд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (ХЭМАА) бодлогоо олон улсын ISO45001:2018 стандартад нийцүүлэн шинэчилсэн юм. Цаашид бид ажилтан болон бизнесийн үйл ажиллагаанд оролцогч талуудынхаа эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг илүү сайжруулж, ослыг хамгийн бага түвшинд байлгахын тулд ХЭМАА-ны менежментээ тасралтгүй хөгжүүлэхээр зорьж байна.

Бид эрсдэлд суурилсан хандлага, урьдчилан сэргийлэх тогтолцоог ХЭМАА-ны үндсэн

зарчмаа болгосноор өндөр эрсдэл бүхий нэгж, хэсгүүд, ажлын байруудад анхааран, гэнэтийн онцгой байдалд бэлэн байх, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Эрсдэлийн үнэлгээ болон менежмент

Юнител групп нь барилга байгууламж, үйл ажиллагааны процесс болон ажилтны ажил үүрэгт эрсдэлийн үнэлгээ хийн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, өндөр эрсдэлтэй ажлын байруудад онцгойлон анхаарал хандуулан, хяналт тавьж ажилладаг. Мөн эрсдэлийн менежментийн журмаа шинэчлэн сайжруулж, PDCA (Plan Do Check Act) циклийн дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.


Бид 2023 онд дараах эрсдэлийн үнэлгээнүүдийг хийж, сайжруулах арга хэмжээ авч ажилласан*:

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Бид Эс Эс Ай Эм Эн ХХК-аар байгууллагынхаа объектуудад гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж, түүнд нийцүүлэн төлөвлөгөөгөө шинэчлэн гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.
Объектын эрсдэлийн үнэлгээ	Оффисын барилга, үйлчилгээний салбар, агуулах зэрэг байгууламжуудад биечилсэн үзлэг хийлгүүлж ажлын орчны эрүүл ахуйн хэмжилт (дуу чимээ, гэрэлтүүлэг, температур, агаарын урсгалын хурд), ундны усны шинжилгээ хийж, гал болон цахилгааны аюулгүй байдал, орчны эмх цэгц зэргийг сайжруулах арга хэмжээг авч ажилласан.
Компанийн ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	Бид компанийн бүх ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй ажлын байруудад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн. Түүнчлэн ажлын онцлогоос шалтгаалан ажилтнуудаа эрүүл мэндийн оношилгоонд оруулан, гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Мөн өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн ажлын гүйцэтгэх үеийн хяналтыг сайжруулахаар ажлын аюулын дүн шинжилгээ хийсэн юм. Ингэснээрээ ажилтан тухайн ажлыг гүйцэтгэх үед өдөр тутмын зааварчилгаа өгөх, гүйцэтгэх зөвшөөрөл олгох зэрэг ажлуудаа тогтмол сайжруулж байна.
Туслан гүйцэтгэгчээр ажил гүйцэтгүүлэх үеийн хяналт	Худалдан авалт болон ажил гүйцэтгэх үеийн бүх үйл ажиллагаанд ХЭМАА-ны хяналт тавин ажиллаж байна. Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгүүлэхдээ: - Сонгон шалгаруулалтад ХЭМАА-ны үзүүлэлтийг оруулж дүгнэх - Бүх гэрээнд ХЭМАА-ны заалт оруулах - Сургалт зааварчилгаа өгөх - Ажлын явцын ХЭМАА-ны хяналт хийх - Ажлын гүйцэтгэлд ХЭМАА-ны гүйцэтгэлийн үзүүлэлтийг оруулж дүгнэдэг. Бид 2023 онд мобайл үйлчилгээний 19, IPTV-ийн 7 туслан гүйцэтгэгч компани, орон нутгийн 31 хамтрагч байгууллагын ажилтнуудад ХЭМАА-ны сургалт орон заавар зөвлөгөө өгч хяналт тавин ажилласан.

*Аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх дээрх ажлуудыг компанийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хэлтсийн ажилтнууд болон холбогдох мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэсэн болно.

Боломжит аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх арга хэмжээнүүдээс гадна бид ажилтнуудын ажлын байран дахь аюул, эрсдэлийг илрүүлж, ХЭМАА-ны нэгжид мэдээлэн, ажиллах орчноо тогтмол сайжруулахаар зорьж байна. Энэхүү

зорилгын хүрээнд бид ажилтнууддаа зориулан ажлын явцад тулгарч буй аюул, эрсдэлийн талаарх мэдээллийг хүргэх платформ хөгжүүлэн ажиллаж байгаа юм.





Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын сургалт, зааварчилгаа

Бид өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа болон Монгол Улсын ХЭМАА-ны сургалт явуулах дүрэм стандарт, компанийн ХЭМАА-ны сургалт, зааварчилгаа зохион байгуулах журамд нийцүүлэн сургалтын хэрэгцээгээ тодорхойлсон бөгөөд жил бүр сургалтын төлөвлөгөөгөө шинэчлэн баталдаг. Бид бүх сургалтаа ажлын цагаар, үнэ төлбөргүй зохион байгуулж байна.

Ажлын байрны онцлогоос шалтгаалан дараах түвшний ХЭМАА-ны сургалтыг зохион байгуулдаг.

Үүнд:

- Шинэ ажилтан
- Нийт ажилтан
- Нэгжийн удирдлагын сургалт
- Менежментийн багийн сургалт
- Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалт

2023 онд 380 АЖИЛТНЫГ дараах сертификаттай сургалтуудад хамруулсан


 <p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт</p>	 <p>Галын аюулгүй байдлын сургалт</p>	 <p>Цахилгааны аюулгүй ажиллагааны сургалт</p>
 <p>Хязгаарлагдмал орчны сургалт</p>	 <p>Өндрийн аюулгүй байдлын сургалт</p>	 <p>Анхны тусламжийн сургалт</p>

Сургалтуудаас гадна өндөр эрсдэлтэй ажлын байруудад ажиллаж буй ажилтнууд хоорондоо мэдлэгээ хуваалцаж, санал солилцох, асуудлаа

шийдвэрлүүлэхээр бүлгийн уулзалтуудыг тогтмол хийдэг. Мөн бид компанийн байгууламж бүр дээр гамшгийн үед ажиллах мэргэжлийн ангиудыг

шинэчлэн байгуулж, үр чадварыг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хийн урьдчилсан, анхан, давтан зааварчилгаануудыг тухай бүрд өгч байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлтүүд*



0.67 Нийт мэдээлсэн ослын хувь (TRIR):

нэг хуанлийн жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох бүртгэгдсэн осол болон өвчлөлийн тоо

0.29

Ажлаас чөлөөлөгдсөн, хязгаарласан эсвэл шилжүүлсэн өдрүүд (DART):

нэг хуанлийн жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох ажлаас чөлөөлөх, ажлыг хязгаарлах эсвэл шилжүүлэх шаардлагатай болсон ослын тоо

7.6

Алдагдсан цагийн хувь (LTC):

хуанлийн нэг жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох ажлын цаг алдсан тохиолдлын тоо (ажилтан бүтэн ээлжээр ажиллах боломжгүй болсон, аливаа ажлаас үүдэлтэй гэмтэл, өвчин)

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс нь тохиолдол бүрийг судлан дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг бөгөөд бид тус комисст 2023 онд ХЭМАА-ны нэгж, хүний нөөц, хуулийн багуудаас төлөөлөл оруулан бүтцийн өөрчлөлт хийсэн. Комисст багтсан гишүүд осол, гэмтлийн тохиолдлуудыг бүртгэх, судлах сургалтад хамрагдан ажиллаж байна.

* Ажлын байрны нөхцөл, үйл ажиллагаанаас шалтгаалсан нас баралт, гэмтэл, өвчлөл зэргийг оруулсан болно


Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр

Юнител групп ажилтнуудынхаа эрүүл мэнд болон аюулгүй орчинд ажиллахад анхаараад зогсохгүй тэднийг ажилдаа амжилт гаргах, гэр бүл болон сонирхол хоббиндоо цаг зарцуулж ажил амьдралын тэнцвэрээ зохицуулахад нь бодит дэмжлэг үзүүлэхийг зорин ажиллаж байгаа билээ. Мөн бид "Эрүүл ажилтан" хөтөлбөрөөрөө дамжуулан ажилтнуудынхаа бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн олон санаачилгыг хэрэгжүүлээд байна.

2023 онд бид ажилтнуудынхаа эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих дараах ажил, санаачилгуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- 1 Бид олон улсын JCI магадлан итгэмжлэгдсэн Интермед эмнэлэгтэй хамтран ажилтнуудынхаа ажлын онцлогоос шалтгаалан эрүүл мэндийн олон төрлийн үзлэг шинжилгээг тогтмол хийлгэж байна. Шинжилгээнд хамрагдсаны дараа бид ажилтан тухайн ажлын байранд ажиллахад эрүүл мэндийн хувьд боломжтой эсэх, эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь хэрхэн өөрчлөгдсөн талаар дүгнэлт гаргадаг. Ингэснээрээ ажилтан эрүүл мэндийн шалтгаанаас болж осол гэмтэлд өртөх, хийж байгаа ажлаас нь үүдэлтэй өвчлөлд өртөхөөс урьдчилан сэргийлдэг. Бид ажилтныхаа эрүүл мэндийн нууцлалыг онцгой анхаарч энэ талаарх зүйл заалтыг гэрээндээ тусган түүнийгээ мөрдлөг болгон ажилладаг билээ.
- 2 Мөн манай байгууллага ажилтнуудынхаа сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүдийг зохион байгуулж эхэлсэн бөгөөд Нугтом сэтгэл зүйн эрүүл мэндийн төвтэй хамтран хэрэглэгчийн үйлчилгээний ажилтнуудаа 3 сарын сургалтад хамруулаад байна.
- 3 Бид улирлын чанартай томуу болон томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх аяныг зохион байгуулсан юм.
- 4 Мөн ажилтан бүрдээ алжаал тайлах бариа заслын төвөөр үйлчлүүлэх 5 удаагийн эрхийн бичиг олгосон байна.
- 5 Ажилтнуудаа хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор фитнесийн 10 төвд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлээд байна.



 **779**

ажилтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан



661 ажилтан сайн дураараа
вакцинжуулалтад хамрагдсан



37% Үндсэн
ажилтнуудын

Ажилтнуудын тогтвор суурьшил, идэвх оролцоо

Хүн бүр ажлын байрандаа сэтгэл ханамжтай, тогтвортой ажиллана гэдэг бол компанийн хувьд яах аргагүй чухал үнэт зүйл билээ. Ажилтнууд идэвх оролцоо сайтай, дундаршгүй хүсэл тэмүүлэлтэй байх нь бидний үйл ажиллагааг илүү тодотгож өгдөг тул, энэ нь цаашлаад тогтвортой ирээдүйг бий болгоход нөлөөлдөг. Тиймээс бид ажилтнуудаа сэтгэл хангалуун байлгаж, гүйцэтгэж буй ажлуудыг нь ямагт шударгаар үнэлдэг юм. Мөн ажилтнуудынхаа ажил амьдралын тэнцвэрт байдлыг чухалчилж, санхүүгийн хувьд байнгын орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, ажилтан бүрийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхийг тэргүүн зорилгоо болгон ажиллаж байна.

2023 онд

Юнител группт нийт



+460

хүн шинээр ажилд орсон

Сургалт, хөгжил

Юнител групп нь бүхий л ажилтнуудынхаа харилцаа хандлага, үр чадвар, мэргэжлийн өсөлтөд нь онцгой анхаарч чаддаг. Энэ нь тэдэнд ажлын байр болон цаашдын карьертаа итгэл дүүрэн байх боломжийг өгдөг чухал ач холбогдолтой. Бид хамт олны уур амьсгалыг сайжруулан ажилласнаар шинэ цагийн хөгжил, дэвшлийг түүчээлж буй гэдэгт итгэдэг.


Юнителчүүд бид өөрт тулгарсан асуудлыг даван туулахдаа багийн гишүүдээсээ тусалцаа авах, шууд болон шууд бус удирдлагатайгаа санаа бодлоо хуваалцах, зэргээр чөлөөтэй харилцдаг. Бид өдөр тутамдаа ажлын байран дээрээ шинээр суралцаж, цаашлах ирээдүйг хамтдаа бүтээдгээрээ онцлогтой. 2023 онд бид хувь хүний гүйцэтгэлд суурилсан тогтолцооноос илүү багийн гүйцэтгэлд суурилсан тогтолцоо руу шилжиж, үр дүнд нь багаараа нэг зорилгын төлөө ажиллах, хамтдаа хөгжих боломж бүрдээд байна.





Юнител группийн сургалт хөгжлийн бодлого нь дотоод нөөц бололцоогоо ашиглах, хамтдаа хөгжих гэсэн үндсэн зарчимд суурилсан байдаг. Өөрийн мэдлэг, үр чадвараа бусадтай хуваалцах, цааш түгээж байдаг нь бидний хамгийн том соёл юм.

2023 онд:



705 ажилтан бусадтай мэдлэг, туршлагаа хуваалцах уулзалтад оролцсон




2,765 цагийг бусдадаа мэдлэгээ хуваалцахад зарцуулсан

Бид ажилтнуудынхаа дунд тусгай үр чадваруудыг нь хөгжүүлэх зорилготой chapter болон community-г бий болгож эхэлсэн. 2023 онд бид Robotic Process Automation (RPA) буюу процесс автоматжуулалтын талаарх мэдлэгийг хуваалцах зорилгоор "Citizen Developers Chapter"-г бий болгосон. Ингэснээр манай ажилтнууд 'No-Code' аргачлалаар процессуудаа автоматжуулж, ажилдаа бүтээмжтэйгээр хандах боломжтой болсон.

Мөн тоон мэдээлэл дээр ажилладаг шинжээч нар маань аливаа өгөгдөлд дүн шинжилгээ хийх, бусад үр чадвараа сайжруулах зорилготой "Data Community"-г байгуулсан. Ирэх жилүүдэд бид энэхүү chapter болон community-г үргэлжлүүлэн зохион байгуулахын зэрэгцээ цаашид ажилтнуудынхаа олон төрлийн хүсэл сонирхол тулгуурласан, орчин үеийн шинэ community-г байгуулахаар түүштай ажиллаж байна.

2023 онд:

Citizen Developers Chapter-ийн уулзалтуудад




15 ажилтан хамрагдсан




10 цагийг нийт гишүүд мэдлэгээ хуваалцахад зарцуулсан

Data Community



6 удаагийн уулзалт хийж, мэдлэгээ хуваалцсан



144 ажилтан ажилтан давхардсан тоогоор хамрагдсан

Манай ажилтнууд, шинэ үр чадварт суралцахын тулд MCS Academy болон дотоодын бусад сургалтад идэвхтэй хамрагддаг. Мөн Udemy, Coursera, Melearn, Data School зэрэг 4 төрлийн


онлайн платформыг сонгож, англи, монгол хэлээр сургалтад суун, чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх боломжтой юм.




MCS Academy-ийн



127 удаагийн сургалтад



1,169 ажилтан хамрагдаж




5,894 цагийг сурч хөгжихөд зарцуулсан


At other organizations




35 удаагийн сургалтад



560 ажилтан хамрагдаж



4,660 цагийг сурч хөгжихөд зарцуулсан



7.71 ЦАГ

Бүтэн цагийн нэг ажилтанд ногдох сургалтын дундаж цаг (мэдлэг, туршлага хуваалцах болон chapter / community-н уулзалтууд, танхим болон онлайн сургалтуудыг оруулаад)

Санхүүгийн сайн сайхан байдал, тэтгэмж

Юнител групп нь ажилтнуудынхаа амьдрал, санхүүгийн боломжийг үргэлж сайжруулахын төлөө ажилладаг. Бид цалин, урамшууллын шударга тогтолцоотой бөгөөд цалингийн хэмжээ нь нас, хүйс, хөдөлмөрийн чадвар алдалт, гэр бүлийн байдал, бие давхар эсэх зэрэг хувийн шинж чанаруудаас үл хамаардаг. Бид эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн өрсөлдөхүйц цалинг санал болгодог ба Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан тогтоомжийн дагуу нэмэлт олговрыг олгодог.

2023 онд бид дотоодын ажилтнууддаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Toki аппликейшнээр дамжуулан хэрэглээний зээлийн платформ нэвтрүүлсэн. Зээлийн мэдээллийн санд ямар мэдээлэлтэй байхыг үл харгалзан бүх ажилтнуудад ажилласан жилээс хамааран зээлийн эрх үүсэх бөгөөд эхний 2 сар ямар ч хүүгүй гэдгээрээ онцлогтой.

Цаашлаад М-Си-Эс Групп нь ажилтнууддаа компанийн зүгээс олгож буй хөнгөлөлт

Нийгмийн идэвх, оролцоо

Бид ажилтнуудынхаа хооронд үнэ цэнтэй харилцааг тогтоож, хамт олны уур амьсгалыг эерэг байлгах үүднээс олон төрлийн сонирхолтой арга хэмжээг зохион байгуулдаг. Компанийн газар бүрээс спорт, урлагийн баг бүрдэж хоорондоо өрсөлдөхийн хажуугаар хоорондоо танилцаж, бие биеэсээ үр чадваруудыг суралцсаар байна. Ингэхдээ бид тэмцээн, уралдааныг ихэвчлэн ажлын өдрүүдэд



урамшууллын талаарх мэдээллийг төвлөрсөн байдлаар түгээх зорилготой платформ бүтээсэн нь MCS Benefits. Ажилтнууддаа зөвхөн MCS Benefits платформтой харилцах боломжтой М банкны данс үүсгэж, энэ дансаар дамжуулан сар бүр мөнгөн урамшуулал олгодог. Ажилтнууд уг урамшууллаа ашиглан М-Си-Эс Группийн компаниуд болон түнш байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг онцгой хөнгөлөлттэй үнээр авах боломжтой болоод байна.

зохион байгуулж буй нь эргээд ажилтнууд амралтын өдрөө гэр бүлдээ зориулах боломжийг нь бүрдүүлж өгч буй явдал юм.



2023 оны ажилтнуудад чиглэсэн онцлох үйл явдлуудаас дурдахад:

- Дуулах дуртай ажилтнуудад зориулсан "Open Mic" арга хэмжээ
- UG Arena-д зохион байгуулагдсан спортын уралдаан тэмцээн
- "Холбоочдын баяр"
- Ажилтнуудын авьяас билгийг тодотгосон "Unitel's Got Talent"
- Оффис шинэ жилийн үдэшлэг "Let's Glow"



Нийгэмд тустай ажлууд

Монголын хамгийн өргөн сүлжээтэй Юнител групп нь ажил олгогчийн хувьд томоохон төлөөллийн нэг. Бид байгаль орчинд ээлтэй, нийгэмд тустай ажлуудыг тогтмол хийдэг бөгөөд хүмүүст эерэг нөлөөг цогцлоох туйлын хүсэлтэй билээ. Тиймээс олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагынхаа хүрээнд нийгмийн сайн сайхны төлөө тогтвортой байдлыг эрхэмлэж, гэрэлт ирээдүйг бүтээхийг хүсдэг. Юнител групп нь төрийн болон төрийн бус байгууллагуудтай нийгэмд эергээр нөлөөлж болохуйц ажлууд дээр хамтарч ажиллахад үргэлж нээлттэй байдаг. Бид өөрсдийн

үйлчилгээ болон кампанит ажлуудаар дамжуулан нийгэмд тулгарч буй асуудалд шийдэл хайж, ажилтнуудаа нийгмийн идэвхтэй, хариуцлагатай иргэд болгож төлөвшүүлэх зорилгыг үрдаа тавин ажиллаж байна.

Ажилтанд хамаарах сайн дурын ажлууд

Юнител групп нь өөрсдийн хоёр мянга гаруй ажилтны нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд улирал бүр сайн дурын ажлууд зохион байгуулдаг.

Бид анх 2020 оны шинэ жилийн баяраар нийгэмд хайр, халамжаар дутагдаж байгаа хүүхдүүдэд харилцагч нартайгаа хамтран бэлэг барьсан “Бэлгээ бэлэглэе” аяныг санаачилсан билээ. 2023 онд Юнител групп нь Монгол Улсын алслагдсан бүсэд амьдарч байгаа бяцхан хүүхдүүдийг баярлуулах зорилготой **“Жаргалтай, Гайхалтай”** бэлгийн аяныг гурав дахь жилдээ амжилттай зохион байгуулаад байна. Хүүхэд төвтэй шинэ жилийн баярын концепц маань нийт 510 бяцхан зүрхэнд баяр баясгалан, хүсэл тэмүүлэл бэлэглэж чадсан юм. Энэхүү аянд манай компанийн нийт ажилтнууд оролцдог ба тэд сэтгэл зүрхээ зориулж хүүхэд бүрийн хүсэл сонирхол, эрдэм мэдлэгт зориулсан бэлгүүдийг бэлддэг нь бахархууштай.



Юнител группийн ажилтнууд



510

бэлгийг ДОРНОД, УВС, ГОВЬ-АЛТАЙ аймгуудад суугаа бага ангийн хүүхдүүдэд зориулан тусгайлан бэлтгэн хүргүүлээ

Ажилтанд хамаарах сайн дурын ажлууд

Юнител групп нь Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран "Цусаа хандивляя" хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж өдгөө тав дахь удаагаа амжилттай зохион байгуулаад байна. Тус арга хэмжээнд хамрагдан цусаа хандивлахыг хүссэн ажилтнуудад мэргэжлийн эмч, сувилагч нар заавар зөвлөгөө өгч, тусгайлан шинжилгээ хийсний дараа хөтөлбөр хэрэгждэг.

Мөн энэ үеэр Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь цусаа хандивлах хөтөлбөрийг хүмүүст бие даан уриалахаас илүүтэй албан байгууллагуудтай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байна гэдгийг онцолж байв.



45

ажилтан цусаа хандивласан



135

хүний амь насыг аврахуйц хэмжээний цус

Эерэг хамтын ажиллагаа

Юнител групп нийгэмд тулгамдаж буй асуудлыг тодорхой хэмжээнд бууруулах, эерэг нөлөөлөл үзүүлэхийн тулд маркетингийн платформ болон харилцаа холбооны дэд бүтцээ ашиглан чухал мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх замаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.

Бид 2023 онд нийгмийн хариуцлагын хүрээнд дараах байгууллагуудтай хамтран, ажилласан байна:

- Харилцаа холбооны зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн 16-аас доош насны хүүхдүүдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой "Хүүхдэдээ зөвхөн хүүхдийн дугаар" аян
- Хүүхдийг аливаа зохисгүй агуулга бүхий контентоос сэргийлэх зорилготой "E-Mongolia E-Kids" аян
- Онцгой байдлын ерөнхий газраас зарласан цаг уурын аюулт үзэгдэл болон гал түймрээс сэргийлэх талаарх мэдээлэл

Эдгээр болон бусад компанид ажлын хүрээнд:



9 САЯ ЗУРВАС

орон даяар илгэсэн



4 УДААГИЙН

мэдээлэл хүргэлт олон нийтийн сүлжээнд хийсэн



1,623

хүний хандалт уг мэдээллээс авсан

Цахим хуваагдлыг бууруулах ажлууд

Өнөөгийн дижитал эрин зуунд мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) хүртээмж сайжирч, бүх нийтээрээ технологи ашиглах чадвартай байх нь улс орны хөгжилд чухал нөлөөтэй болоод байна. Гэвч нийгэм, эдийн засаг болон газар зүйн байршлаас шалтгаалан цахим хуваагдал бий болж МХХТ-ийн хүртээмжийн тэгш бус байдал үүсээд байгаа юм. Үүнээс болж хүмүүс хоорондын хөгжлийн ялгаа улам нэмэгдэж нийгмээс тусгаарлагдах, орлогын тэгш бус байдал бий болох, хувь хүн болон нийгмийн хөгжил удаахрах зэрэг сөрөг нөлөөтэй. Мөн цахим хуваагдал нь цахим зах зээлийн хөгжлийг удаашруулснаар энэ нь бизнесийн инновац болон улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулаад байгаа юм.

Монгол орон эрс тэс уур амьсгалтай төдийгүй өргөн уудам газар нутагт хүн ам сийрэг суурьшсан байдаг нь үүрэн холбооны дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэхэд томоохон сорилт болж алслагдсан бүс нутгуудын мэдээллийн

хүртээмжтэй байдалд шууд нөлөөлж байна. Хүн амын 1/3 нь нүүдэлчин амьдралын хэв маягтай байдгаас шалтгаалан хот суурин газрын иргэд сүүлийн үеийн мэдээ мэдээллийг богино хугацаанд авах, цахим хэрэглээний сургалтад хамрагдах зэрэг технологийн ашиг тусыг илүү хүртэж байгаа юм. Харин хөдөө орон нутгийн иргэдэд эдгээр боломж хязгаарлагдмал байгаа нь хот, хөдөөгийн цахим ялгааг бий болгоод байна.



Юнител групп нь улсын хэмжээнд сүлжээний холболтын гол зохицуулагч болохын хувьд улс орны холбооны дэд бүтцийг бүтээн байгуулж, сүлжээнийхээ цар хүрээ, хүртээмжийг тасралтгүй нэмэгдүүлэн цахим хуваагдлыг бууруулах чиглэлд өөрийн хувь нэмрээ оруулсаар байна. Түүнчлэн бид компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд улс орон даяар цахим бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхэд нөлөө үзүүлэхүйц ажлуудыг санаачлан амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.



Unitel HUB хөтөлбөр

Юнител групп хот хөдөөгийн цахим боловсролын ялгааг багасгах эрхэм зорилгын хүрээнд Unitel HUB хөтөлбөрийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн билээ. Бид тус хөтөлбөрийн хүрээнд аймаг бүрд Unitel HUB төвийг байгуулж, хөдөө орон нутагт цахим хэрэглээний сургалтуудыг зохион байгуулан үйл ажиллагаагаа тогтвортой байлгахад анхаарч ажиллаж байна. Unitel HUB төв нь цахим сургалт явуулах боломж бүхий сургалтын танхим гэхээсээ илүүтэй олон нийтийн цахим боловсролыг дээшлүүлэх зорилготой хувь хүний хөгжлийн орчин юм.

Бид 2023 оны хувьд 11 аймагт Unitel HUB төвийг нээж улсын хэмжээнд нийт 12 төвтэй болжээ. Эдгээр төвийг шаардлагатай цахим төхөөрөмжүүд болон сургалтын материалаар бүрэн хангасан бөгөөд бэлтгэгдсэн чадварлаг багш нарын бүрэлдэхүүн тус төвийг удирдан ажиллуулж байна. Бид оновчтой байршлыг тодорхойлох, танхимуудыг тохижуулах, сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулах зэрэг үйл явцыг удирдан чиглүүлэхдээ НҮБ-ын Хүн амын сан (UNFPA), Women in Tech, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар (хуучнаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв) зэрэг олон талын оролцогч талуудтай хамтран ажиллаж байгаа билээ.



* Энэхүү зурагт Unitel HUB төслийн үйл ажиллагаа эхлэхээс ашиглалтын үе хүртэлх бүх үйл явц болон оролцогч талуудын үүрэг оролцоог харуулсан болно

UNITEL HUB 12 аймагт нээгдлээ




Unitel HUB төвийн тогтвортой үйл ажиллагааны гол цөм нь RoboKID, ElectroKID сургалтууд бөгөөд тус сургалтууд нь 15 хүртэлх насны хүүхдүүдэд Шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи (ШИМТ)-ийн чиглэлийн мэдлэг олгох, сонирхлыг нь дэмжих зорилготой юм. RoboKID сургалт нь төрөл бүрийн робот угсарч, түүн дээрээ код бичих чадварыг олгодог бол ElectroKID сургалт нь электроникийн

үндсэн зарчмуудыг сургах зорилготой юм. RoboKID сургалтад Roborobo, ElectroKID сургалтад Arduino гэсэн сургалтын хэрэгслүүд багтсан бөгөөд хүүхдүүдэд онол болон практик хосолсон мэдлэгийг цогцоор нь олгодгоороо онцлогтой. Unitel HUB хөтөлбөр нь боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг эрхэмлэн “Боломжийг хүн бүрд” уриан дор бүх насны хүмүүст нээлттэй байдлаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд HUB төвүүд нь шаардлагатай бүхий л технологийн нөөцүүдээр бүрэн хангагдсан байдаг. Unitel HUB төвд бүх насны хүмүүс интернэт ашиглаж программ хангамжийн үр чадвараа дээшлүүлэн төрөл бүрийн уулзалт болон багаар ажиллах боломжтой юм. Харин хүүхдүүдийн хувьд технологийн

төрөл бүрийн хэрэгслүүд ашиглан бие даан суралцах орчинд өөрийгөө хөгжүүлэх, дээр дурдсан сургалтуудад хамрагдах боломжтой байдгаараа онцлогтой. Тус төвүүдийн сургалт нь сургуулийн насны охидыг шинжлэх ухаан, технологид сонирхолтой болоход эергээр нөлөөлж, цаашлаад ирээдүйн эмэгтэй инженерүүдийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.


- 30** Сургалтын нийт элсэлтийн тоо (2023 оны төгсгөл хүртэл)
- 323** Төгсөгчдийн тоо (2023 оны төгсгөл хүртэл)
- 1:8** Төгсөгчдийн хүйсийн харьцаа (эмэгтэй : эрэгтэй)

Бид 2024 онд Unitel HUB төвөө 9 аймгийн төвүүдэд байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд энэхүү төвүүддээ одоогийн хэрэглэгчдийн санал хүсэлтийг тусган боловсролын хөтөлбөрүүдээ улам сайжруулан илүү олон хүнд хүргэхийг зорьж байгаа юм. Энэхүү хөтөлбөр нь хөдөө орон нутгийн бүх хүнд шаардлагатай цахим төхөөрөмжүүдийг ашиглах боломж олгосноороо цаашид хүмүүсийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



“Нээлттэй сурах бичиг” төсөл

Цахим хуваагдлыг бууруулах зорилгын хүрээнд бид технологи ашиглан нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг үр дүнтэйгээр шийдвэрлэх боломжуудыг эрэлхийлдэг билээ. Тэр ч утгаараа бид “Нээлттэй сурах бичиг” төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь тоон технологийг ашиглан сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлж, оюутнуудыг тэгш боломжоор ханган, ШИМТ салбар сонирхогчдыг дэмжих зорилготой юм. Төслийн хүрээнд бид М-Си-Эс Кока-Кола болон М Плас компаниудтай хамтран МУИС-ийн дөрвөн тэнхимд түгээмэл хэрэглэгддэг ШИМТ салбартай холбоотой заавал судлах хичээлүүдийн 26 сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Ингэснээрээ бүх оюутан эдгээр цахим номуудыг М Book аппликейшн ашиглан онлайнгаар унших боломжтой болсон билээ.



Нийлүүлэлтийн хэлхээний менежмент

Юнител группийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө нь компанийн үйл ажиллагаанаас гадна бүтээгдэхүүн үйлчилгээ ханган нийлүүлэгчдээс тодорхой хэмжээнд хамаарч байдаг. Иймээс бид хамтрагч байгууллагууддаа тогтвортой, ёс зүйтэй үйл ажиллагаа явуулах шаардлага тавьдаг билээ. Мөн компанийн үнэт зүйлс, хэм хэмжээг стандартжуулан дагаж мөрдөх Нийлүүлэгчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. Үүний үр дүнд туслан гүйцэтгэгч компаниудыг өрсөлдөөний тэгш боломжоор хангаад зогсохгүй худалдан авалтын илүү үр ашигтай шинэ нийлүүлэгчдийг татан оролцуулах боломжтой юм. Мөн энэ нь тогтвортой, хамтын ажиллагаанд суурилсан, хүртээмжтэй бизнесийн орчныг бий болгодог.

➔ supplier.mcs.mn/policy холбоосоор нэвтэрч, Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэмтэй танилцана уу.

Бид байгууллагуудтай хамтран ажиллахдаа болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдахаас гадна байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг илүүтэйгээр дэмжихийг эрмэлздэг. Тиймээс худалдан авалтын сонголт, шийдвэртээ нийлүүлэгчдийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг тусгахыг зорин ажиллаж байгаа билээ. Одоогоор бидний хувьд, улсын орны нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс шалтгаалан худалдан авалтын процессоо өөрчлөх боломж хязгаарлагдмал буй. Хэдий тийм ч, хариуцлагатай нийлүүлэлтийн хэлхээг бий

болгох нь бидний нэн тэргүүнд анхаарах асуудлуудын нэг тул үүнд чиглэсэн алхмуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Энэ ч утгаараа үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилго дор дотоодын* ханган нийлүүлэгчдэд давуу боломж олгодог. Түүнчлэн эмзэг бүлгүүдийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, илүү хүртээмжтэй, олон талын төлөөлөл бүхий бизнесийн орчныг бүтээхэд хувь нэмрээ оруулах үүднээс нийгмийн цөөнхийн өмчит** аж ахуйн нэгжүүдийн түншлэлээ өргөжүүлэхээр идэвхтэй судалж байна.

Нийлүүлэгчийн портал:
➔ www.supplier.mcs.mn

Нийт ханган
нийлүүлэгчдийн
81.6%
дотоодын
нийлүүлэгчид

Тэднээс
100
ТЭРБУМ ТӨГРӨГИЙН
бүтээгдэхүүн үйлчилгээ
худалдан авсан.

Энэ нь компанийн нийт
худалдан авалтын үнийн
дүнгийн
33.6%

*Монголд Улсад үйл ажиллагаа явуулдаг ханган нийлүүлэгчид

**Эмэгтэйчүүд, тусгай хэрэгцээт хүмүүс, үндэстний цөөнх гэх мэт бүлгүүдийн эзэмшил бүхий аж ахуйн нэгжүүд

Нийлүүлэгчийн портал

2023 онд М-Си-Эс Групп олон улсын жишигт нийцсэн худалдан авалтын цогц системийг нэвтрүүлж, дотоодын байгууллага, хувь хүн бүрд нийлүүлэгчээр бүртгүүлэн, худалдан авалтад оролцох боломжийг олгосон. Ингэснээр харилцагч байгууллагууд тендерт бүртгүүлэх, үнийн санал илгээх, шалгаруулалтын үйл явцтай танилцаж, тодруулга авах зэргээр худалдан авалтын мэдээллийг нэг дороос харж, бүх үе шатыг хянах боломжтой. Түүнчлэн Юнител групп болон түүний охин компаниудын хувьд уг портал дээр үүсэх нийлүүлэгчдийн нэгдсэн бүртгэлд үндэслэн туслан гүйцэтгэгчдийн нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх боломжтой болж байгаа юм.



ЗАСАГЛАЛ

Бидний хувьд хэрэглэгчдэдээ чанартай, найдвартай үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ компанийн дотоод процессоо оновчлох нь урт хугацааны тогтвортой байдлын нэг хэсэг гэж үздэг. Мөн бид бизнесийн ёс зүйн хэм хэмжээ, шударга ёс, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын орчны комплаенсийг эрхэмлэн, дагаж мөрддөг билээ.

- 1 Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал
- 2 Бизнесийн ёс зүй
- 3 Бизнес процессын менежмент
- 4 Компанийн засаглал



Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал

Дэлхийн бүхий л улс оронд цахим харилцаа, олон нийтийн сүлжээ хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болсон энэ цагт мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь нэн тэргүүний асуудал болоод байна. Иймээс бид хэрэглэгчийн цахим орчны найдвартай хэрэглээг хангахын тулд дэд бүтэц, сүлжээний чанараа сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлаа сахин хамгаалах арга замаар тогтвортой үйл ажиллагааг эрхэмлэж буй.

Сүлжээний тэлэлт ба чанарын сайжруулалт

Бид Монгол орон даяар харилцаа холбооны хүртээмжийн зөрүүг багасгах зорилгоор алслагдсан сум суурин газруудад сүлжээний цар хүрээгээ тэлэн, үйлчилгээгээ илүү өргөжүүлсээр байгаа билээ. Тухайлбал, 2023 онд суурин станцын тоог 8.3 хувиар нэмэгдүүлсэн нь сүлжээний цар хүрээгээ 5 хувь тэлсэн үзүүлэлт болсон юм.

Түүнчлэн бид сүл зогсолт болон аливаа гэмтэл саатлаас сэргийлэхийн тулд үйлчилгээнийхээ чанар, найдвартай байдлыг тогтмол сайжруулдаг

билээ. Тухайлбал, бид Дата төвд хяналтын системийг байрлуулснаар цахилгаан хангамж, хөргөлтийн систем болон бусад төхөөрөмжийн үйл ажиллагааг бодит цагийн горимоор хянаж, алдаа гарвал шууд илрүүлэх боломжийг бий болгосон. Үүнээс гадна, эрчим хүч тасалдах өндөр магадлалтай хот орчмын суурин станцуудын үүсгүүрт зөөврийн цахилгаан хураагуур болон ухаалаг цоож байрлуулан, гэмтэл саатлыг арилгах процессыг оновчилсон юм.




Эрсдэлийн менежмент

Байгалийн гамшиг, цахим халдлага, эрчим хүчний эх үүсвэрийн тасалдал зэрэг тааварлашгүй хүчин зүйлс нь харилцаа холбооны компаниудын санхүү болон нэр хүндэд өндөр эрсдэл учруулж, тогтвортой үйл ажиллагааг доголдуулах эрсдэл болж байдаг. Тиймээс Юнител групп нь болзошгүй томоохон эрсдэлүүдээ тодорхойлж, үр дүнтэй шийдвэрлэх аргуудыг боловсруулж, хэрэгжүүлдэг. Үүнийг манай компанийн эрсдэлийн удирдлагын баг хариуцдаг ба эрсдэлийн үнэлгээнүүдээ нэгтгэн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит ба эрсдэлийн хороонд тайлагнах үүрэгтэй. Улмаар бүх

түвшний оролцогч талуудыг хамарсан иж бүрэн хяналт хийх боломж бүрддэг.

Мөн бид том болон жижиг аливаа саатлын үед үйл ажиллагаагаа хэвийн явуулах үүднээс холбогдох өндөр нарийвчлал бүхий журмыг баримтлан ажилладаг. Үүнээс гадна, болзошгүй эвдрэл гэмтлийн үед бэлтгэлтэй байхын тулд сервер, сүлжээний дэд бүтцээ өргөтгөн сайжруулж, чанар, хүртээмжийг нь баталгаажуулах туршилтуудыг тогтмол хийж байна.



Мэдээллийн аюулгүй байдал

Дэлхий дахинаа интернет, олон нийтийн сүлжээг ашиглан үйлддэг цахим халдлага нь жил ирэх тусам нэмэгдэж буй. Энэ нь компанийн болон хэрэглэгчийн нэн чухал мэдээллийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулаад зогсохгүй хууль эрх зүйн зохицуулалтын эрсдэлийг ч дагуулж байдаг. Иймд Юнител группийн хувьд хэрэглэгчдийнхээ хувийн мэдээллийг хамгаалах үйл ажиллагааг компанийн бодлогын түвшинд авч үздэг.

2022 онд бид мэдээллийн аюулгүй байдал

(МАБ)-ын удирдлагын тогтолцооны (ISMS) "алтан стандарт" гэж хүлээн зөвшөөрөгдсөн ISO 27001 стандартын гэрчилгээг авч, одоог хүртэл баримтлан ажиллаж буй. Мөн АНУ-ын Худалдааны танхимын харьяа агентлаг Стандарт, технологийн үндэсний хүрээлэн (NIST)-ийн тогтолцоог мөрдөж ажилладаг.

Ийнхүү бид гаднын болон дотоодын мэдээллийн системд учирч болох эрсдэл, сул талуудыг тодорхойлохдоо сүүлийн үеийн дэвшилтэт илрүүлэх хэрэгслүүдийг ашиглах, нэвтрүүлэлтийн шалгалтуудыг

тогтмол зохион байгуулах, салбартаа тэргүүлэх экспертүүдээс зөвлөх үйлчилгээ авах зэрэг алхмуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Мөн бид суурин болон зөөврийн компьютер, виртуал дэлгэцийн төхөөрөмжүүд (VDI), сервер зэрэг сүлжээнд холбогддог бүхий л хэрэгслүүдэд хамгаалалтын программ хангамжуудыг суулгасан ба үүндээ хяналт тавих замаар мэдээллийн сангийн аюулгүй байдлын системээ тогтмол бэхжүүлж байна.



Үүнээс гадна, хүний үйлдлээс хамааралтай болзошгүй эрсдэлүүдийг арилгахын тулд бид ажилтнуудынхаа хүрээнд жил бүр мэдээллийн аюулгүй байдлын талаар кампанит ажил хэрэгжүүлдэг. Энэ нь тэдэнд интернет, олон нийтийн сүлжээг зүй зохистой ашиглах, кибер халдлагыг таньж мэдэн урьдчилан сэргийлэх, мэргэжлийн түвшинд хариу үйлдэл үзүүлэх зэрэг мэдлэг чадварыг олгодог давуу талтай. 2023 онд уг санаачилгын хүрээнд бид мэдээлэл хуваалцах хөтөлбөр, фишинг симуляцийн шалгалт, мэдээллийн аюулгүй байдлын асуумж, сорил авах гэх мэт арга хэмжээг зохион байгуулсан байна.

2023 онд МАБ-ын кампанит ажлын хүрээнд:



1,569 ФИШИНГ И-МЭЙЛ

ажилтнууддаа илгээж, таньж тайлагнах чадварыг нь үнэлсэн



4 УДААГИЙН ЗӨВЛӨМЖ

и-мэйлээр илгээсэн



1 ПОДКАСТ

ажилтнуудын нийгмийн сүлжээний сувгуудаар түгээсэн

Жил ирэх бүр ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт сайжирч байна.

2023 онд өмнөх жилтэй харьцуулахад:



Нийт оролцогчдын тоо

7.3% -иар өссөн.



Боломжит дээд оноо авсан ажилтнуудын тоо

1-ЭЭС 42 болж өссөн.



Бизнесийн ёс зүй

Юнител групп нь бизнесийн үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээ, шударга ёсны зарчим, олон улсын болон дотоодын хууль тогтоомж, бодлого журмыг баримталдаг. Үүнээс гадна, зөвхөн компанийн үйл ажиллагаа болон ажилтнуудаар хязгаарлагдахгүйгээр хамтран ажилладаг бүхий л оролцогч талууддаа бизнесийн ёс зүйг түгээх нь бидний эрхэм зорилго юм.

Бид Ёс зүйн дүрмээрээ ажилтнуудын албан үүргээ гүйцэтгэхдээ баримтлах зарчим, үнэт зүйлсийг тодорхойлсон бөгөөд үүнийг ажилтан бүр өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэхийг эрмэлздэг. Үүнээс гадна, группийн салшгүй нэг хэсэг болох харилцагч, гэрээлэгч, гүйцэтгэгч нартаа ч үг ёс зүйн хэм хэмжээний шаардлагаа ижилхэн тавьж, нийлүүлэгчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байна.

2023 оноос эхлэн бид GRC* модель болон эрсдэлд суурилсан арга барилыг төлөвшүүлэх зорилгоор бизнесийн үйл ажиллагааны чиглэл бүрд комплаенсийн эрсдэлээ үнэлж эхэлсэн. Улмаар болзошгүй эрсдэлүүдээ илрүүлж, тэдгээрийг бууруулахад шаардлагатай арга хэмжээнүүдээ тодорхойлсон юм.

* Governance, Risk, and Compliance буюу Засаглал, эрсдэл, комлаенс

Авлигын эрсдэлээс сэргийлэх

Юнител групп нь аливаа тохиолдолд авлигын ямар ч хэлбэрээс ангид байх, үл хүлээн зөвшөөрөх зарчмыг баримталдаг. Тиймдээ ч бид Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор 'StarCompliance' системийг амжилттай нэвтрүүлээд буй. Манай компанийн зүгээс гэрээлэгчдэд өгсөн болон тэднээс авсан бэлэг, бизнес уулзалт, улс төр болон сайн үйлсийн хандив зэргийг комплаенсийн нэгж харилцан ажилладаг бөгөөд эдгээрийг системд бүртгэснээр шаардлагатай хяналтуудыг амжилттай гүйцэтгэж байна.

2023 онд

5,596 Бэлэг харилцагчдад өгсөн

164 Бэлэг харилцагчдаас хүлээн авсан

+

18 Бизнес уулзалт, энтертайнментын

тухай мэдүүлгийг хүлээн авч, аливаа зүй бус нөлөөллөөс сэргийлж ажилласан.

Ашиг сонирхлын зөрчил

Юнител группийн Ашиг сонирхлын зөрчлийн журмын дагуу ТУЗ-ийн бүрэлдэхүүн, 6 ба түүнээс дээш зэргийн ажилтнууд, худалдан авалтын бүх ажилтан жил бүр өөрийн бодит болон болзошгүй зөрчлийг мэдүүлэх үүрэгтэй. Комплаенсийн нэгж нь ажилтнуудын мэдүүлсэн бодит болон болзошгүй зөрчлийн мэдүүлэг бүрд тохирох зөвлөмжийг хүргүүлж, зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авдаг.

2023 онд:

Нийт ажилтнуудын
93%
мэдүүлэг илгээсэн.




26 болзошгүй зөрчлийг

илрүүлж, тухайн ажилтан болон шууд удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

Ёс зүйтэй байх болон авлигаас сэргийлэх сургалтууд

Юнител группийн хувьд бүх түвшний ажилтнууд жил бүр Ёс зүйн дүрэм, Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого, Ашиг сонирхлын зөрчлийн журмын сургалтад заавал хамрагдах үүрэгтэй байдаг. Бид үг сургалтыг үр дүнтэй, хүртээмжтэй байлгахад анхаарч, онлайн хэлбэрт шилжүүлэн, ажилтнууд хаанаас ч, хэзээ ч орох боломжтойгоор шийдсэн. Мөн 2022 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн бид болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор мэдээлэл бэлтгэн ажилтнууддаа тогтмол хүргэж байна.

2023 онд:

1,518 хүн цагийн сургалт зохион байгуулсан



1,722 ажилтан хамрагдсан

Олон улсын хориг арга хэмжээнээс сэргийлэх

Юнител групп Ёс зүйн дүрэмдээ заасны дагуу аливаа худал хуурмаг зүйл, хууль бус үйлдлийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримталдаг. Түүнчлэн бид Монгол Улсын хуулийн хүрээнд үүрэг хүлээгээгүй боловч олон улсын сайн жишгийг даган, НҮБ, АНУ-ын OFAC, Их Британи болон Европын Холбооны Хориг арга хэмжээний жагсаалтад нэр дурдагдсан эрсдэл бүхий компани, улс төрийн нөлөө бүхий этгээд, хувь хүнтэй аливаа харилцаа тогтоож ажиллахаас сэргийлдэг.

2023 онд:

Олон улсын LexisNexis системийн мэдээллээс

7.6 сая гүйлгээ



3,269 гэрээлэгчийг

шалгаж, мөнгө угаалт болон бусад хууль бус ажиллагаанаас сэргийлсэн.

Шүгэл үлээх

Манай байгууллагын Ёс зүйн дүрмийн дагуу ажилтнууд маань хууль тогтоомж, дүрэм журам зөрчигдсөн тухай мэдвэл тэр даруй шууд удирдлага, комплаенсийн нэгж, компанийн Ёс зүйн хороо эсвэл Аудит, эрсдэлийн хороонд мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв болзошгүй зөрчлийг холбогдох албан тушаалтнуудад ил мэдэгдэхэд хүндрэлтэй байвал 'SpeakOut' сувгаар дамжуулан мэдэгдэх боломжтой. Юнител групп нь энэ тохиолдолд мэдээлэгчийг чандлан нууцалдаг бөгөөд түүний эсрэг аливаа сөрөг арга хэмжээ авахыг хориглодог.

SpeakOut
суваг

Утас: +976-88882027

Веб: <http://speakout.mcs.mn>

E-mail: speakout@mcs.mn



Бизнес процессын менежмент

Бизнесийн тасралтгүй, тогтвортой үйл ажиллагааг хангах нь найдвартай ажлын байрыг бүрдүүлэх, ажилтны сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлт, үндэсний тогтвортой байдлыг хадгалахад чухал үүрэгтэй билээ. Тиймээс манай байгууллага ирээдүй хойч үедээ бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй хүргээд зогсохгүй найдвартай, таатай ажлын байраар хангахыг зорьж байна. Бид менежментийн суурь зарчим, бизнесийн үйл явц, арга техникүүдийг тогтмол сайжруулан ажилладаг бөгөөд ажилтнуудынхаа ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын орчныг сайжруулан сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэхийг хичээн ажиллаж байна.

Бид хэрэглэгчийн экспериенсийг сайжруулах стратегийн зорилго тавьж, үүний хүрээнд 2023 онд бүх төрлийн нөөцөө оновчтой хуваарилах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бизнесийн хурдыг өсгөж нийлүүлэлтийн хугацааг багасгах, мөн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилтан болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээр бизнес процессуудаа дахин загварчлах хөтөлбөрийг эхлүүлсэн билээ. Мөн бид системчлэх, арилгах, бууруулах, оновчлох зарчмын дагуу хэрэглэгчдийнхээ хэрэгцээг чухалчлан хэт төвөгтэй процессыг хялбаршуулах, стандартжуулах, улмаар байнга давтагддаг процессуудыг автоматжуулах зэргээр олон чиг үүрэг бүхий багуудыг зохион байгуулан ажилласан байна. Бид салбартаа батлагдсан бизнесийн процесс болон хэрэглээний бүдүүвчүүдийг ашиглан стратегийн, үндсэн болон дэмжих процессуудаа системтэйгээр тодорхойлж шаардлагагүй



процессуудыг халан, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч байгаа юм.


Бизнесийн процессуудаа дахин загварчлах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бид үйл ажиллагаагаа хөнгөвчлөх, илүү уян хатан болгоход ахиц гаргаж амжилттай ажиллаа. Манай байгууллага 2023 онд процессын бүрэн зураглал гаргах зорилгоор санхүү, хүний нөөцийн менежмент тэргүүтэй энтерпрайз хүрээний процессоо дахин загварчилж эхэлсэн юм. Харин 2024-2025 онд хэрэглэгчийн экспериенс, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх тэргүүн эгнээний процессуудаа анхааран ажиллахаар төлөвлөөд байна.

Компанийн засаглал


Юнител группийн засаглал нь хувьцаа эзэмшигчдийнхээ урт хугацааны өгөөжийг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангахад чиглэдэг. Мөн бид байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын аливаа зорилтыг нэгдсэн төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлдэг бөгөөд шийдвэр бүрд удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид зэрэг шат шатны оролцоог бий болгодог. Өөрөөр хэлбэл, группийн тогтвортой байдлын тэргүүлэх чиглэлийг оролцогч талуудтай стратегийн түвшинд уялдуулж, үр дүнтэй удирдах боломжийг олгодог юм.

ТУЗ-ийн олон талт байдал


Юнител групп нь нийт хувьцаа эзэмшигчдээ бүрэн төлөөлж чадах, мэдлэг туршлага бүхий хувь хүмүүсээр төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өө бүрдүүлэхийг эрмэлздэг. Тэгвэл 2023 онд Юнителийн ТУЗ нь үндсэн таван гишүүн (олон улсын туршлагатай, хараат бус нэг гишүүний хамт), нэг орлох гишүүн, саналын эрхгүй нэг ажиглагч гишүүн гэсэн нийт долоон хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.



7 гишүүний 3 нь хараат бус, орлох эсвэл ажиглагч гишүүн



7 гишүүний 1 нь эмэгтэй



7 гишүүний 4 нь 50-иас доош настай

БОНЗ-д тавих ТУЗ-ийн хяналт

Юнител группийн ТУЗ нь дэргэдэх хороодын тусламжтайгаар компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал зэрэг томоохон эрсдэлүүдийг хянадаг. Мөн тусгайлсан анхаарал шаарддаг тодорхой асуудлуудыг шийдвэрлэхээр тусгай хороодыг үүсгэн байгуулж ажиллах тохиолдол ч бий. Тухайлбал, БОНЗ-ын хороо нь тогтвортой байдлыг дэмжих төсөл, санаачилгуудын хэрэгжилт, үр ашгийн талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулдаг. Харин Аудит, эрсдэлийн хорооны хувьд компанийн БОНЗ-ын бодлого, түүний хэрэгжилт, хууль эрх зүйн нийцэл, компанийн нэр хүндтэй холбоотой болон бусад эрсдэл зэргийг удирдах зорилгоор хяналт, зөвлөмж өгч ажилладаг. ТУЗ болон түүний дэргэдэх хороод улирал бүр ээлжит хурал, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан уулзаж, шийдвэр гаргадаг.

2023 онд ТУЗ болон түүний дэргэдэх хороод нийт дөрвөн удаа хуралдсанаас гурван нь зайнаас буюу видео хэлбэрээр, нэг нь Улаанбаатар хотноо биечлэн уулзаж, нийт 37 удаагийн шийдвэр гаргасан.

БОНЗ-ын удирдлага

Манай компанийн хувьд бизнесийн үйл ажиллагааныхаа чиглэл бүрд байгаль орчин, нийгмийн асуудлуудыг уялдуулан авч үздэг бөгөөд тогтвортой байдлын төлөө хүчин чармайлтаа сайжруулахад бүхий л оролцогч талыг дэмжин, хамтран ажиллаж байна. Энэ ч утгаараа Юнител группийн Маркетинг хариуцсан дэд захирал нь БОНЗ-ын бодлогын төвлөрсөн хэрэгжилт, тайлагналыг хариуцдаг бол менежментийн багийн бусад бүх захирал өөрийн хариуцсан газарт тогтвортой байдлын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хэрэгжилтийг хангадаг.

ХАВСРАЛТ

Энэхүү тайланд Юнител болон Юнивишн компанийн 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллийг тусгасан бөгөөд тайлангийн бичвэрийг Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын дагуу боловсруулж, манай салбарын Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн тайлагналын стандартад уялдуулсан болно.

- 1 Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд ба тэдгээрийн тайлбар
- 2 Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс
- 3 Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс
- 4 Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын индекс

Санхүүгийн бус тайлагнал болох тухай

Санхүүгийн бус мэдээлэл нь тухайн мэдээллийн онцлог, тодорхойлох арга барилын хязгаарлагдмал байдлаас үүдэн хэмжилтийн эргэлзээг үүсгэж болно. Иймээс энэхүү тайланд тусгасан зарим мэдээлэл нь таамаглалд үндэслэн боловсруулагдлаа. Хэмжилтийн ялгаатай ч хүлээн зөвшөөрөгддөг арга барилуудыг ашигласны улмаас хэмжигдэхүүний үр дүнгүүд ялгаатай гарах боломжтой. Түүнчлэн нарийвчлалын арга барил ч өөр байдлаар илэрч болно.

Мэдээллийн үнэн зөв байдал

Энэхүү тайланд тусгасан мэдээллийг бэлдэх, болон үнэн зөв байдлыг Юнител группийн удирдлага хариуцна. Тайланд дурдсан мэдээллийг баталгаажуулалтын дотоод процедурын дагуу хянасан бөгөөд манай тогтвортой байдлын үйл ажиллагаа болон түүний гүйцэтгэлийг үнэн зөвөөр илэрхийлж байгаа гэдэгт итгэлтэй байна. Бид БОНЗ-ын тайлагналын хамрах хүрээний дагуу материаллаг асуудлуудаа тодорхойлон, өгөгдөл цуглуулах процессоо тогтмол сайжруулсаар байна. Тайланг бэлдэх үеийн байдлаар Юнител групп нь БОНЗ-ын индикатор, шинжилгээнд хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэдэггүй.



Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд болон тэдгээрийн тайлбар

Материаллаг асуудал	Тайлбар
Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, холбогдох эрсдэлийг үнэлж удирдах, энэ чиглэлд технологийн боломжийг ашиглах зэргээр бизнесийн үйл ажиллагаандаа уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогыг тусгах
Эрчим хүчний хэмнэлт ба сэргээгдэх эрчим хүч	Эрчим хүчний хэрэглээний байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулахын тулд компанийн бүх үйл ажиллагаанд цахилгаан хэрэглээг бууруулах, хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр рүү шилжих зэрэг стратегийг баримтлах
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хог хаягдлын зохицуулалт	<ul style="list-style-type: none">Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээг хийх, дахин боловсруулах, дахин ашиглах, буцаан татах зэрэг стратегийг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахХэрэглэгчдэд аливаа бүтээгдэхүүн үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг олгох
Аюултай болон хатуу хог хаягдал	Компанийн үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдлыг зохицуулах (буруулах, дахин боловсруулах, дахин ашиглах, устгах)
Усны хэрэглээ	Компанийн үйл ажиллагааны улмаас усны нөөцөд үзүүлэх одоогийн болон ирээдүйн нөлөөг бууруулах стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэх
Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал	<ul style="list-style-type: none">ШИМТ (STEM)-д суурилсан ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, цахим болон хэвлэл мэдээллийн боловсролд хөрөнгө оруулахБүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн хүртээмжтэй байдлыг дэмжсэн үйл ажиллагаа явуулах
Гамшгийн үеийн хариу арга хэмжээ	Гамшгийн бүх үед үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө ба үүнд сүлжээний бэлэн байдал, хариу арга хэмжээ, хандив тусламж, ажилтнуудын оролцоо, сайн дурын үйл ажиллагаа зэрэг багтана. Мөн анхны тусламж үзүүлэх, аврах багийнхны хүчин чармайлтыг дэмжих, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тухай ойлголт юм.
Үйлчилгээний хүртээмжтэй байдал	Тусгай хэрэгцээт болон өндөр настай хэрэглэгчдийн хэрэгцээнд тохирох хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох
Олон нийтийн оролцоо ба хандив	<ul style="list-style-type: none">Компанийн үнэт зүйл, тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй сайн үйлсийг дэмжих, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллахХандивын аян, сайн дурын үйл ажиллагаанд ажилтнуудын оролцоог дэмжих
Бүтээгдэхүүний үйлчилгээний нөхцөл, зар сурталчилгааны ил тод байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх хариуцлагатай, үнэн зөв мэдээллийг хүргэж, зар сурталчилгааны ил тод байдлыг хангах
Хариуцлагатай хэрэглээ ба бүтээгдэхүүний аюулгүй байдал	Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг өөрт болон гэр бүлийнхэндээ хамгийн тохиромжтой, аюулгүй байдлаар ашиглахад нь зориулж шаардлагатай мэдлэг мэдээллээр хангах
Нийлүүлэлтийн гинжин сүлжээ дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал	Нийлүүлэгчид болон харилцагчдаас хөдөлмөрийн аюулгүй байдал, бизнесийн ёс зүй, нийгэм, байгаль орчны стандарт, хэм хэмжээг мөрдөж ажиллахыг шаардах

Хүний эрх	<ul style="list-style-type: none">Хүний эрхийн магадлан шинжилгээ хийхОролцогч талуудтай харилцах бүх үед хүний эрхийг хүндэтгэж хамгаалах
Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал	Ажилтнуудын ажлын байран дээрх эрүүл, аюулгүй байдлыг хангах, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн хөтөлбөрт хамруулах
Ажилтнуудын олон талт, тэгш байдал, оролцоо	Бие биеэсээ ялгаатай ажилтнуудыг төвлөрүүлэх, бүх ажилтныг сурч, өсөж хөгжих, тэгш боломжоор хангах, байгууллагын соёлд суралцуулах
Ажил горилогчийг татах, ажилтнуудын оролцоог нэмэх, ажилтныг хадгалах	Авьяаслаг, идэвх зүтгэлтэй ажилтнуудыг татах, хадгалж үлдэх стратегийг хэрэгжүүлэх (суралцах, өсөж хөгжих таатай боломжоор хангах, ажлын цагийн болон ажиллах уян хатан нөхцөлийг бий болгох, ажилтны сайн сайхан байдлыг дэмжих, ажлын байраар дамжуулан олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх гэх мэт)
Сүлжээний чанар, найдвартай байдал	<ul style="list-style-type: none">Сүлжээний найдвартай байдал, хурд, хамрах хүрээ, ерөнхий гүйцэтгэлийг хангахын тулд тогтмол хөрөнгө оруулалт хийн сайжруулахУрьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд сүлжээний найдвартай байдлыг хангах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах
Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал	Сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөлгүй ашиглах болон халдлагаас урьдчилан сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх
Хувийн нууц	Хэрэглэгчийн хувийн мэдээлэлд хэн нэгэн хандах боломжийг хязгаарлах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх
Технологийн инновац	Хиймэл оюун (AI), юмсын интернэт (IoT), 5G, машин сургалт (ML) зэрэг технологийн дэвшлийг бүтээгдэхүүн, үйлчилгээндээ нэвтрүүлэх
Зохицуулалтын нийцэл	Нийцлийн сургалт, аудит зэргээр бизнесийн үйл ажиллагааг шударга байлгах процедуруудыг дагаж мөрдөх
Интернэтийн засаглал ба дижитал эрх чөлөө	Интернэтийн тэгш хүртээмжийг хангахад хөрөнгө оруулах, сайжруулах
Бизнесийн ёс зүй, ёс зүйтэй соёл	Залилан, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил зэргийг бодлого, журам, сургалтаар удирдах, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх
Шударга өрсөлдөөн	Шударга, тэгш өрсөлдөөнийг хангах
Бизнесийн тогтвортой, тасралтгүй байдал	Нийлүүлэлтийн сүлжээний бат бөх, тогтвортой байдлыг хангах, технологийн хувьсал, нийгэм, засаглал, улс төр, байгаль орчны өөрчлөлт, сорилтуудад дасан зохицох чадвараа дээшлүүлэх
ТҮЗ-өөс БОНЗ-д тавих хяналт	ТҮЗ нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, боломж, нийлүүлэлтийн хариуцлагатай гинжин сүлжээ, хөдөлмөрийн харилцаа зэрэг БОНЗ-тай холбоотой чиг үүргийг хариуцаж, хяналт тавьдаг байх

Манай компанийн бизнесийн хувьд БОНЗ-ын ач холбогдолтой асуудлуудыг тодорхойлох, эрэмбэлэх зорилготой материаллаг байдлын үнэлгээг хийхдээ дээрх тайлбарыг ашигласан. [Материаллаг байдлын матрицаас](#) илүү дэлгэрэнгүйг үзнэ үү.

Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс

Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд	Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд
GRI 2: Ерөнхий тайлагнал 2021					
Байгууллага болон тайлагналын үйл ажиллагаа					
2-1	Байгууллагын мэдээлэл	Юнител групп нь Улаанбаатар хотод төвтэй, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.	2-12	Нөлөөллийг удирдахад байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүрэг	БОНЗ-ын хандлага Засаглал > Компанийн засаглал
2-2	Байгууллагын тогтвортой байдлын тайлагналд хамрагдсан этгээдүүд	БОНЗ-ын хандлага Хавсралт	2-13	Нөлөөллийг удирдах хариуцлагын хуваарилалт	Засаглал > Компанийн засаглал
2-3	Тайлагналын хугацаа, давтамж болон холбогдох этгээд	Тайлангийн хамрах хугацаа: өөрөөр тусгаагүй бол 2023 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 31. Давтамж: Юнител групп Тогтвортой байдлын тайлангаа жил бүр гаргаж байна. Олон нийтэд түгээсэн хугацаа: 2024 оны дөрөвдүгээр сар Холбогдох: esg@group.unitel.mn	2-14	Тогтвортой байдлыг тайлагнахад ТУЗ-ийн оролцоо	Засаглал > Компанийн засаглал
2-4	Мэдээллийн тодруулга	Тодруулга байхгүй.	2-15	Ашиг сонирхлын зөрчил	Засаглал > Бизнесийн ёс зүй
2-5	Хөндлөнгийн баталгаа	Юнител групп тогтвортой байдлын тайландаа хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэдэггүй.	2-16	Нэн чухал асуудлын харилцаа холбоо	БОНЗ-ын хандлага
Үйл ажиллагаа болон ажилтнууд					
2-6	Үйл ажиллагаа, үнэ цэнийн гинж болон бусад бизнесийн харилцаа холбоо	Нийгэм > Нийлүүлэлтийн хэлхээний менежмент	2-17	ТУЗ-ийн нэгдсэн мэдлэг	Засаглал > Компанийн засаглал
2-7	Ажилтнууд	Нийгэм > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал	2-18	ТУЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ	Засаглал > Компанийн засаглал
2-8	Хөдөлмөрийн гэрээт бус ажил гүйцэтгэгчид	Нийгэм > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал	2-19	Цалин урамшууллын бодлого	N/A
Засаглал					
2-9	Засаглалын бүтэц болон бүрэлдэхүүн	Нийгэм > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал	2-20	Цалин урамшууллыг тогтоох процесс	N/A
2-10	ТУЗ-ийн гишүүдийн томилгоо болон сонгон шалгаруулалт	Засаглал > Компанийн засаглал	2-21	Цалин урамшууллын харьцаа	N/A
2-11	ТУЗ-ийн дарга	Засаглал > Компанийн засаглал	Стратеги, бодлого, үйл ажиллагаа		
2-22 Удирдлагаас гаргасан мэдэгдэл БОНЗ-ын хандлага > Гүйцэтгэх захирлын зурвас					
2-23 Бодлогын амлалт					
2-24 Бодлогын амлалтын хэрэгжилт					
2-25 Сөрөг нөлөөг сааруулах процесс					
2-26 Зөвлөгөө авах, асуудал дэвшүүлэх механизм					
2-27 Хууль болон зохицуулалтын орчны нийцэл Засаглал > Бизнесийн ёс зүй					
2-28 Гишүүнчлэл					
Оролцогч талуудын оролцоо					
2-29 Оролцогч талуудын оролцоог хангах хандлага БОНЗ-ын хандлага > Оролцогч талуудын оролцоо					
2-30 Үйлдвэрчний эвлэл Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг.					

Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд
GRI 3: Материаллаг асуудлууд 2021		
3-1	Материаллаг асуудлуудыг тодорхойлох процесс	БОНЗ-ын хандлага > БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ
3-2	Материаллаг асуудлуудын жагсаалт	Хавсралт > Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд болон тэдгээрийн тайлбар
Материаллаг асуудал: Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал + Эрчим хүчний хэмнэлт ба сэргээгдэх эрчим хүч		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	
GRI 302: Эрчим хүч 2016		
302-1	Байгууллагын эрчим хүчний хэрэглээ	
302-3	Эрчим хүчний эрчим	
302-4	Эрчим хүчний хэрэглээг бууралт	
GRI 305: Хүлэмжийн хийн ялгарал 2016		
305-1	Компанийн шууд (Хамрах хүрээ 1) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал	Байгаль орчин > Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал
305-2	Эрчим хүчний шууд бус (Хамрах хүрээ 2) хүлэмжийн хийн ялгарал	
305-4	Хүлэмжийн хийн ялгарлын эрчим	
305-5	Хүлэмжийн хийн ялгарлын бууралт	
GRI 201: Эдийн засгийн гүйцэтгэл 2016		
201-2	Санхүүгийн үр дагавар болон бусад эрсдэл болон боломжууд	
Материаллаг асуудал: Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хог хаягдлын зохицуулалт		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	
GRI 306: Хог хаягдал 2020		
306-1	Ялгаруулсан хог хаягдал болон түүний ач холбогдол бүхий нөлөө	Байгаль орчин > Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент
306-2	Хог хаягдлын ач холбогдол бүхий нөлөөний удирдлага	
306-3	Ялгаруулсан хог хаягдал	
306-4	Зорилго, зориулалтыг нь өөрчлөн ашигласан хог хаягдал	
Материаллаг асуудал: Аюултай болон хатуу хог хаягдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	
GRI 306: Хог хаягдал 2020		
306-1	Ялгаруулсан хог хаягдал болон түүний ач холбогдол бүхий нөлөө	Байгаль орчин > Хог хаягдлын менежмент
306-2	Хог хаягдлын ач холбогдол бүхий нөлөөний удирдлага	
306-4	Зорилго, зориулалтыг нь өөрчлөн ашигласан хог хаягдал	
Материаллаг асуудал: Олон нийтийн оролцоо ба хандив		

Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Байгаль орчин > Байгаль хамгаалал Нийгэм > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд Нийгэм > Нийгэмд тустай ажлууд
GRI 304: Биологийн олон янз байдал 2016		
304-2	Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний биологийн олон янз байдалд үзүүлэх ач холбогдол бүхий нөлөө	Байгаль орчин > Байгаль хамгаалал
304-3	Хамгаалсан болон нөхөн сэргээсэн төрөл зүйл	
304-4	Үйл ажиллагаа явуулж буй талбайд нутаглаж буй Улаан номонд орсон төрөл зүйл	
GRI 413: Орон нутаг болон олон нийт 2016		
413-1	Орон нутгийн олон нийтийн оролцоот үйл ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ болон хөгжлийн хөтөлбөрүүд	Нийгэм > Нийгэмд тустай ажлууд
413-2	Орон нутгийн олон нийтэд учруулж буй ач холбогдол бүхий бодит болон боломжит сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа	Байгаль орчин > Байгаль хамгаалал Нийгэм > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд Нийгэм > Нийгэмд тустай ажлууд
Материаллаг асуудал: Ажилтнуудын олон талт, тэгш байдал, оролцоо		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	
GRI 405: Олон талт болон тэгш боломж 2016		
405-1	Удирдлага болон ажилтнуудын олон талт байдал	Нийгэм > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
Material topic: Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	
GRI 403: Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал 2018		
403-1	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны систем	
403-2	Аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ болон тохиолдлын судалгаа	
403-3	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ	
403-4	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай ажилтны оролцоо, зөвлөгөө, харилцаа холбоо	Нийгэм > Ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллах нөхцөл, сайн сайхан байдал
403-5	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай сургалт, зааварчилгаа	
403-6	Ажилтны эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	
403-7	Бизнесийн харилцаатай шууд холбоотой хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөнөөс урьдчилан сэргийлэх болон бууруулах	
403-8	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын системээр зохицуулагдаж буй ажилтнууд	
403-9	Ажилтай холбоотой гэмтэл бэртэл	
403-10	Ажилтай холбоотой эрүүл мэндийн хүндрэл	
Материаллаг асуудал: Ажил горилогчийг татах, ажилтнуудын оролцоог нэмэх, ажилтныг хадгалах		

Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Нийгэм > Ажилтнуудын тогтвор суурьшил, идэвх оролцоо
GRI 202: Зах зээлийн оролцоо 2016		
202-1	Анхан түвшний ажилтны жендерээр ялгасан стандарт цалин урамшуулал болон хөдөлмөрийн доод хэмжээний харьцаа	
GRI 401: Ажил эрхлэлт 2016		
401-1	Шинэ ажилтнууд болон ажилтны эргэц	
401-2	Бүтэн цагийн хөдөлмөрийн гэрээтэй ажилтнуудын урамшуулал	
GRI 404: Сургалт хөгжил, боловсрол 2016		
404-1	Ажилтнуудын жилд сургалтад хамрагдсан дундаж хугацаа	
404-2	Ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, шилжин ажиллахад дэмжих хөтөлбөрүүд	
404-3	Гүйцэтгэлийн болон карьер хөгжлийн үнэлгээ тогтмол авч буй ажилтнуудын хувь	
Материаллаг асуудал: Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Нийгэм > Цахим хуваагдлыг бүүруулах ажлууд
GRI 413: Орон нутаг болон олон нийт 2016		
413-1	Орон нутгийн олон нийтийн оролцоот үйл ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ болон хөгжлийн хөтөлбөрүүд	
413-2	Орон нутгийн олон нийтэд учруулж буй ач холбогдол бүхий бодит болон боломжит сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа	
Материаллаг асуудал: Нийлүүлэлтийн гинжин сүлжээ дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Нийгэм > Нийлүүлэлтийн хэлхээний менежмент
GRI 204: Худалдан авалтын үйл ажиллагаа 2016		
204-1	Орон нутгийн нийлүүлэгчдээс авсан зарцуулалтын хувь	
Материаллаг асуудал: Сүлжээний чанар, найдвартай байдал + Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Засаглал > Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон дэмжсэн үйл ажиллагаа	
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	
Материаллаг асуудал: Бизнесийн тогтвортой, тасралтгүй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Засаглал > Бизнес процессын менежмент
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	
Материаллаг асуудал: Бизнесийн ёс зүй, ёс зүйтэй соёл + Шударга өрсөлдөөн + Хувийн нууц		

Код #	Тайлагнах асуудлууд	2023 оны хариултууд
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Засаглал > Бизнесийн ёс зүй
GRI 205: Авлигын эсрэг үйл ажиллагаа 2016		
205-2	Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагааны тухай сургалт, мэдээлэл	
Материаллаг асуудал: ТҮЗ-өөс БОНЗ-д тавих хяналт		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Засаглал > Компанийн засаглал
GRI 405: Олон талт болон тэгш боломж 2016		
405-1	Удирдлага болон ажилтнуудын олон талт байдал	

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс

Бизнесийн байгууллагууд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС буюу IFRS) болон Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (ТБНБСЗ буюу SASB)-ийн стандартуудыг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-д ээлтэй хөрөнгө оруулалт хийж, шийдвэр гаргах боломжтой. Түүнчлэн компаниуд тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн

талаар тодорхой ойлголттой байснаар өөрсдийн үйл ажиллагаа төдийгүй улс орны нийгэм, эдийн засагт үнэ цэнтэй хувь нэмэр оруулах юм.

Бидний хувьд энэхүү тайланг бэлтгэхдээ ТБНБСЗ: Харилцаа холбоо (SASB: Telecommunications) стандартыг мөрдөж, тайлагналын сэдэв болон нягтлан бодох бүртгэлийн метрикуудээ тодорхойлсон. Хүснэгтэд тоон болон

чанарын мэдээллүүдийг тусгасан бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар оруулсан болно. Уг үзүүлэлтүүд нь 2023 оны 12-р сарын 31-нийг дуусталх хугацааг хамарна.

Тайланд тусгасан мэдээллүүдийг материаллаг байдал эсвэл санхүүгийн нөлөөг тодорхойлох зорилгоор ашиглахыг хориглоно.

SASB үйл ажиллагааны метрикууд

Сэдэв	SASB Код	Хэмжих нэгж	2023 оны хариулт
Үүрэн сүлжээ холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.A	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Үүрэн бус сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.B	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Өргөн зурвасын сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.C	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Сүлжээний урсгалын эзлэхүүн	TC-TL-000.D	Петабайт (ПБ)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл

SASB нягтлан бодох бүртгэлийн метрикууд

Сэдэв	SASB Код	Requested metric	Хэмжих нэгж	2023 оны хариулт
Үйл ажиллагааны байгаль орчинд үлдээж буй үл мөр	TC-TL-130a.1	Зан төлөвийн сурталчилгаа ба хэрэглэгчийн нууцлалтай холбоотой бодлого, үйл ажиллагаа	Гигажоул (ГЖ)	176,914
		Хоёрдогч зорилгоор мэдээллийг нь ашигласан хэрэглэгчдийн тоо	Хувь (%)	84.8
		Хэрэглэгчийн нууцлалтай холбоотой шүүх үйл ажиллагааны үр дүнд учирсан мөнгөн хохирол	Хувь (%)	7.9

Мэдээллийн нууцлал	ТС-TL-220a.1	Зан төлөвийн сурталчилгаа ба хэрэглэгчийн нууцлалтай холбоотой бодлого, үйл ажиллагаа	Тайлбар бичвэр	Юнител групп нь 2021 оны Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах талаарх дотоод бодлого, журмаа шинэчлэн баталсан. Энэ хүрээнд бид хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авдаг. Юнител группийн хувьд бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хүндэтгэх, хамгаалахаас гадна хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, задруулахтай холбоотой холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн ажилладаг.
Мэдээллийн аюулгүй байдал	ТС-TL-220a.2	Хоёрдогч зорилгоор мэдээллийг нь ашигласан хэрэглэгчдийн тоо	Тоо (#)	100 хувь буюу үйл ажиллагааны тайланд тусгасан нийт хэрэглэгч Юнител групп нь зөвшөөрлийн маягтад дурдсанчлан бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах эсвэл зорилтот хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгохын тулд хэрэглэгчийн зан төлөвийн шинжилгээ хийж, шаардлагатай мэдээллийг ашигладаг.
	ТС-TL-220a.3	Хэрэглэгчийн нууцлалтай холбоотой шүүх үйл ажиллагааны үр дүнд учирсан мөнгөн хохирол	сая төгрөгөөр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-220a.4	(1) Хууль сахиулах байгууллагаас хэрэглэгчийн мэдээллийг авах тухай ирүүлсэн хүсэлтийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Хууль сахиулах байгууллагын хүсэлтэд хамрагдсан хэрэглэгчийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(3) Хүсэлтийн дагуу мэдээллийг өгсөн хувь	Хувь (%)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл

Мэдээллийн аюулгүй байдал	ТС-TL-230a.1	(1) Мэдээллийн халдлагын тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Хувийн мэдээллийн эзлэх хувь	Хувь (%)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(3) Өртсөн хэрэглэгчдийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-230a.2	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүдийг таних, шийдвэрлэх	Тайлбар бичвэр	Бид мэдээллийн технологийн системийнхээ аюулгүй байдлыг хангахын тулд аливаа эрсдэлийг илрүүлэх арга хэмжээг байнга авдаг. Мөн одоо байгаа болон шинээр хэрэгжиж буй системийг үнэлэхийн тулд дотоод нэвтрэлтийн туршилтыг тогтмол хийдэг. Ингэснээр хэрэглэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангах ба гуравдагч байгууллагатай хамтран эрсдэлийн зөвлөх үйлчилгээг авч ажиллаж байна. Юнител групп нь ISO 27001 гэрчилгээ авсан ба дотооддоо бид NIST-ийн тогтолцоог баримтлан ажиллаж байна. Үүнээс гадна, бид одоогоор COBIT болон ITIL-ийг жишиг болгон хэрэгжүүлж буй.
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент	ТС-TL-440a.1	(1) Бүтээгдэхүүн эргүүлэн татах хөтөлбөрийн хүрээнд татсан материалын тоо хэмжээ	Тонн (тн)	3.72
		(2) Дахин ашиглахаар сэргээсэн материалын хувь	Хувь (%)	16.7
		(3) Дахин боловсруулахаар сэргээсэн материалын хувь		25.9
		Сэргээсэн материалын (4) Ландфилд оруулсан хувь		0
Өрсөлдөөн ба нээлттэй интернэт	ТС-TL-520a.1	Өрсөлдөөний эсрэг зан үйлийн зохицуулалттай холбоотой шүүх үйл ажиллагааны үр дүнд учирсан мөнгөн хохирлын нийт хэмжээ	сая төгрөг	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл







Өрсөлдөөн ба нээлттэй интернэт	ТС-TL-520a.2	(1) Өөрийн эзэмшлийн ба арилжааны контент татах тогтвортой дундаж хурд	Мегабит/секунд (Mbps)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Бусад контентыг татаж авах сурталчилсан дундаж хурд	Мегабит/секунд (Mbps)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-520a.3	Дараахтай холбоотой эрсдэл ба боломжуудыг хэлэлцэх <ul style="list-style-type: none"> net neutrality paid peering zero rating ба холбогдох үйл ажиллагаа 	Тайлбар бичвэр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Системийн эрсдэлийн удирдлага	ТС-TL-550a.1	(1) Системийн дундаж тасалдлын давтамж	Саатал	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Үйлчилгээний тасалдлын дундаж хугацаа	Цаг	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Системийн эрсдэлийн удирдлага	ТС-TL-550a.2	Үйлчилгээ тасалдах үед саадгүй үйлчилгээ үзүүлэх системүүдийн тухай	Тайлбар бичвэр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын индекс

2015 оны есдүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар ядуурлыг бууруулж, эх дэлхийгээ хамгаалах, бүх талын тогтвортой байдлыг дэмжих 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ыг баталж, 193 орон нэгдэн орсноор

албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Үүгээр дамжуулан бид бүгдийг дэлхий дахинд тулгамдаж буй сорилтуудыг даван гарахад өөрсдийн хувь нэмрээ оруулахыг уриалсан билээ. Юнител групп “Хамтдаа түүрүүлж алхана” уриан дор НҮБ-ын ТХЗ-уудад хүрэхээр хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

ТХЗ-ууд	Хувь нэмэр оруулж буй хамааралтай зорилтууд	Холбоосууд	
 <p>4 QUALITY EDUCATION</p>	<p>Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих</p>	<p>4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх холбогдох үр чадвартай, түүний дотор техник, мэргэжлийн үр чадвартай залуучууд, насан хүрэгсдийн тоог [x] хувиар нэмэгдүүлэх</p> <p>4.5 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх</p> <p>4.a Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах</p>	<p>Цахим хуваагдлыг бууруулах ажлууд</p>
 <p>5 GENDER EQUALITY</p>	<p>Жендерийн тэгш байдлыг хангаж, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах</p>	<p>5.1 Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох</p> <p>5.5 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах</p>	<p>Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал</p>
 <p>7 AFFORDABLE AND CLEAN ENERGY</p>	<p>Хүн бүрийг боломжийн, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүч хэрэглэх боломжоор хангах</p>	<p>7.2 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх</p> <p>7.b 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй орнуудын иргэдийг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангах дэд бүтцийг өргөжүүлж, технологийг шинэчлэх</p>	<p>Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал</p>
 <p>8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH</p>	<p>Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих</p>	<p>8.4 2030 он гэхэд хөгжингүй орнуудын хошуучлан тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн хөтөлбөрт нийцүүлэн байгаль орчны доройтлоос эдийн засгийн өсөлтийг ялгаатай авч үзэх гэсэн хүчин чармайлт, үйлдвэрлэл, хэрэглээний чиглэлээр дэлхийн баялгийн үр ашгийг аажмаар нэмэгдүүлэх</p> <p>8.5 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнтэй ажилд адилхан цалин хөлс олгох</p> <p>8.8 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах</p>	<p>Хог хаягдлын менежмент, Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент, Нийлүүлэлтийн хэлхээний менежмент</p> <p>Ажилтнуудын тогтвор суурьшил, идэвх оролцоо</p> <p>Ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллах нөхцөл, сайн сайхан байдал</p>
 <p>9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE</p>	<p>Уян хатан дэд бүтцийг байгуулж, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг дэмжиж, инновацыг хөгжүүлэх</p>	<p>9.1 Хүн бүрд тэгш, хүртээмжтэй байх талыг голлон анхаарч эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц, түүний бүсийн болон хил дамнасан дэд бүтцийг хөгжүүлэх</p>	<p>Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал</p>

		9.4 2030 он гэхэд нөөц баялгийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлж, цэвэр, байгальд ээлтэй технологи, үйлдвэрлэлийн ажиллагааг нэвтрүүлж, бүх улс орнууд өөрсдийн нөөц чадавхдаа уялдуулан арга хэмжээ авч хэрэгжүүлж, аж үйлдвэрийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор дэд бүтцийг хөгжүүлж, аж үйлдвэрийг боловсронгуй болгох	Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал
		9.с 2020 он гэхэд мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудын хүн амыг хямд үнэтэй интернэтээр хангахыг эрмэлзэх	Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс
	Хот, хүн амын суурьшлыг бүх талын оролцоог хангасан, аюулгүй, эрсдэлийг давах туулах чадвартай, тогтвортой болгох	11.b 2020 он гэхэд бүх талын оролцоог хангах, хөрөнгө баялгийг үр ашигтай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг хот, хүн амын суурьшлын тоог [x] хувиар нэмэгдүүлж, удахгүй гарах Хёгогийн үйл ажиллагааны баримт бичигтэй уялдуулан бүх түвшинд гамшгийн эрсдэлийн цогц менежментийг боловсруулж, хэрэгжүүлэх	Сүлжээний чанар ба мэдээллийн аюулгүй байдал, Бизнес процессын менежмент
	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтцийг бүрдүүлэх	12.4 2020 он гэхэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын баримт бичигт нийцүүлэн химийн бодис болон бүх төрлийн хог хаягдлыг амьдралынх нь мөчлөгийн хугацаанд байгаль орчинд ээлтэй байдлаар зохицуулах	Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент
		12.5 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах	Хог хаягдлын менежмент
		12.6 Хувийн хэвшил, ялангуяа томоохон, үндэстэн дамнасан компаниудыг тогтвортой байдалд чиглэсэн арга ажиллагааг нэвтрүүлж, энэ талаарх мэдээллийг өөрсдийн үйл ажиллагааны тайландаа тусгаж байх явдлыг дэмжих	Хавсралт
		12.7 Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн тогтвортой байдалд чиглэсэн төрийн худалдан авах ажиллагааг дэмжих	Нийлүүлэлтийн хэлхээний менежмент
		12.а Хэрэглээний болон үйлдвэрлэлийн илүү тогтвортой бүтцэд шилжих зорилгоор шинжлэх ухааны болон технологийн чадавхаа бэхжүүлэхэд хөгжиж буй орнуудыг дэмжих	Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал
	Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар яаралтай арга хэмжээ авах	13.2 Цаг уурын өөрчлөлтийн талаарх арга хэмжээг үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд тусгах	Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал
	Дэлхийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, түүний тогтвортой хэрэглээг дэмжих, ойг тогтвортой ашиглах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоох, сэргээх, биологийн олон янз байдал алдагдаж буйг зогсоох	15.4 2030 он гэхэд тогтвортой хөгжилд нэн шаардлагатай үр ашгийг бий болгох уулархаг газрын экосистемийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор уулархаг газрын экосистем, түүний дотор экосистемийн био олон янз байдлыг хамгаалах	Байгаль хамгаалал
		15.а Биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглах үүднээс бүх төрлийн эх үүсвэрээс санхүү хөрөнгө бүрдүүлэх, түүний хэмжээг нь ихээхэн нэмэгдүүлэх	Байгаль хамгаалал
	Тогтвортой хөгжлийн төлөө аюулгүй, бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүрийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан институтийг бий болгох	16.3 Олон улсын болон үндэсний түвшинд хууль ёсыг хөхүүлэн дэмжих, хүн бүрийг хуулиар хамгаалуулах тэгш боломжоор хангах	Бизнесийн ёс зүй
		16.5 Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах	Бизнесийн ёс зүй
	Тогтвортой хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг сэргээж, түүнийг хэрэгжүүлэх арга замыг сайжруулах	17.8 2017 онд гэхэд нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан технологийн банк, шинжлэх ухаан, технологи, инновацын чадавх бэхжүүлэх механизмыг бүрэн ажилд оруулж, технологи, ялангуяа мэдээлэл, харилцаа холбооны технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх	Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс
		17.16 Бүх улс орнуудад, ялангуяа хөгжиж буй орнуудад тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх ажлыг дэмжиж мэдлэг, мэргэшсэн чадвар, технологи солилцох, санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх олон талт түншлэлтэй хослуулан тогтвортой хөгжлийн төлөө дэлхийн түншлэлийг бэхжүүлэх	Цахим хуваагдлыг бууруулах ажлууд



Connect with Unitel LLC
www.unitel.mn
esg@group.unitel.mn